



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

**УЛС ТӨР**

**Н.НОМТОЙБАЯР: ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ 15 ХУВЬ БОЛГОЖ БУУРУУЛЛАА**

II нүүрт

**ДЭЛХИЙ**

**ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ОЛОН УЛСЫН ШҮҮХЭД ӨГӨВ**

IV нүүрт

## Д.СОЛОНГО: ҮНДСЭН ХУУЛЬ БОЛ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ОЮУНЫ ХАМТЫН БҮТЭЭЛ

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс

**ДЭЛХИЙ**

## ОХУ-ын Засгийн газрыг олон улсын шүүхэд өгөв

**Б.ДАВАА**

Украины Засгийн газар ОХУ-ыг террористуудад дэмжлэг үзүүлсэн гэх үндэслэлээр Олон улсын шүүхэд өгчээ. Зүүн Украинд 2014 оноос хойш Засгийн газрын арми болон Оросын талыг дэмжигч

салан тусгаарлагчдын хооронд ширүүн дайн өрнөж эхэлсэн. Улмаар Украины тал ОХУ-аас салан тусгаарлагчдад дэмжлэг үзүүлэн зэвсэг техникээр хангаж байгааг удаа дараа эсэргүүцсэн мэдэгдлийг хийж байлаа. Харин Оросын Засгийн газрын зүгээс тухай

бүрт няцааж байв. Тэгвэл энэ явдалтай холбогдуулан Орос улсыг терроризмыг дэмжсэн гэх шалтгаанаар Украин шүүхэд дуудаж, дотоодын дайны улмаас хохирсон иргэдэд нөхөн олговор олгохыг шаардан Олон улсын шүүхэд ханджээ. Олон улсын

шүүхээс мэдээлснээр Украины Засгийн газраас гаргасан мэдэгдэлд "ОХУ-ын Засгийн газар Украины цэргийн үйл хэрэгт оролцож, терроризмыг санхүүжүүлж, хэдэн зуун мянган украинчуудын хүний эрхийг зөрчсөн" хэмээн дурьдсан байна. Түүнчлэн,

шүүхээс "Терроризмын дэмжиж, Украины нутаг дэвсгэрт салан тусгаарлагчдаар дамжуулан халдлага үйлдсэн тул ОХУ-д олон улсын төвшинд хариуцлага хүлээлгэх"-ийг мөн шаардсан ажээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**



Өдөр -20  
Шөнө -32



Манай сонины I улирлын нэмэлт захиалга явагдаж байна

**Захиалгын үнэ 19800**



Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

Дугаарын **60** мөр

## Золбин ноход зоолж байна

**Э.ТУУЛ**

Утаа ярьж, уушгины хатгалгаанд санаа зовж байх хойгуур бас нэг асуудал үүсээд байгаа нь золбин нохой, муур. Муур ч бас харьцангуй цөөн байх шиг. Харин золбин нохой бүр замаа алдлаа. Өндөр хөгжилтэй улс оронд гэрийн тэжээвэр нохойныхоо тоо судалгааг нарийвчлан гаргадаг төдийгүй нохойгоо тоолж, элдэв халдвараас сэргийлж тогтмол вакцин хийлгэнэ. Бүр нохойны тусгай хэрэгсэл, эм тариа, идэж уудаг хоол хүнс нь хүртэл бэлэн байдаг. Түүгээр ч барахгүй эзэд нь нохойны татвар төлнө. Тийм ч болохоор золбин нохой гэсэн ойлголт бараг байдаггүй гэж хэлж болно. Гэтэл манай улсад энэ асуудал бүр замаа алдлаа. Эзэнтэй, эзэнгүй нь мэдэгдэхгүй ноход гудамж талбайг дүүргэж, хэдэн арваараа сүрэглэн явах боллоо. Өнөөдөр нийслэлд золбин нохойтой хаана л бол хаана таарна. Гэр хороололд бол бүр ярих юм байхгүй. Орон сууцны орц хонгил, төв талбай, Төрийн ордны хашаанд ч таарна. Ямартаа л, манай улсад аялахаар ирсэн жуулчид "Монголд сэрэмжлэх хамгийн гол зүйл нь халаасны хулгайч, золбин нохой. Энэ хоёр байнга дагаж явдаг" хэмээн ярьсан байх вэ дээ. Үүнийг гэрчлэх гэсэн мэт захын хорооллын жалга шуудуу гээд л хаа сайгүй үхсэн нохойн сэг эм. Үүнээс нь элдэв нян, бактер үүсч хаврын салхи шороотой агаарт дэгдэн элдэв өвчин үүсгэж байгааг мэргэжлийн холбогдох байгууллагууд анхаараад ч бүрэн арга хэмжээ авч чаддаггүй. Мөн хотын гудамжинд өдөрт золбин ноход хэдэн арваараа машинд дайруулна. Нийслэлийн гэрийн хорооллуудад нохойгүй айл гэж байхгүй. Түүгээр ч барахгүй гэрэлтүүлэг муутайхан газар, нийслэлийн захын гэр хороололд орой үдэш явахад ганц айлгадаг зүйл нь золбин ноход. Хотын хогийн цэгүүд дээр хог түүгчид нохойтой уралдан, хогоо түүнэ.

Үргэлжлэл нь III нүүрт

**TISSOT**  
SWISS WATCHES SINCE 1853

**ЭХНИЙ 10 ХҮНД**

1.000.000₮ ДЭЭШ ХУДАЛДАН АВАПТАНД VICTORINOX БЭЛЭГПЭНЭ

Хаяг: Хүүхдийн 100 Наран Молл: Утас-99073568  
УИД-ийн баруун талд байрлах Наран Центр: Утас-99066813  
[www.facebook.com/swisswatchshopmongolia/](http://www.facebook.com/swisswatchshopmongolia/)

**ХААН банк**

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2488.00	2502.00
ЕВРО	2634.00	2700.00
ИЕН	21.77	22.20

**Худалгаа хөгжлийн банк**

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2488.00	2502.00
ЕВРО	2632.00	2698.00
ИЕН	21.73	22.30

	Авах	Зарах
ФУНТ	3038.00	3113.00
РУБЛЬ	40.69	44.06
ЮАНЬ	361.00	367.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

## МЭДЭЭЛЭЛ

## Сунгааны үр дүнд юу гэж дүгнэв

Хэнтий аймгаас өнгөрсөн оны арванхоёр дугаар сарын 22-нд эхэлсэн Ардчилсан намын даргын сонгуулийн сурталчилгаа үргэлжилсээр байна. Энэ сарын 17-нд Сэлэнгэ аймагт болсон 22 дахь уулзалтын дараа нэр дэвшигчдээс сунгааны үр дүн хийгээд, үйл явцын талаарх сэтгэгдлээ хэлсэн байна. Тэд сунгааг маш үр дүнтэй болж байгаа хэмээн үнэлж байгаа аж. Сунгааны талаар нэр дэвшигч Д.Эрдэнэбат “Сунгааны явцаас харахад, манай намын бодит байдал, ойлголтын зөрүү, ирээдүйн чиг хандлага гэдэг зүйл дээр байсан олон янзын саналууд нэг тал руугаа цэгцэрч чадаж байна. Таван нэр дэвшигч яг өөр өөрийнхөө өнгөөр, өөр өөрийнхөө үзэл бодлоор санал бодлоо илэрхийлээд явж байгаа нь энэ намын давуу тал. Би энэ таван онгийг энэ намаас өөр хаана ч харахгүй, ийм сунгааг өөр ямар ч нам хийхэд хүнд гэдэгт итгэлтэй байна. Энэ бол Ардчилсан намын дотоод ардчилалынх нь мөн чанар юм” гэжээ. Харин С.Эрдэнэ “Бид тавуулаа 22 уулзалт хийлээ. Эдгээр уулзалтын онцлог юунд байгаа вэ гэхээр тавуулаа таван өөр өнгөөр, таван өөр үзэл бодлоор хөтөлбөрөө тайлбарлаж байна. Хэдий тийм боловч тавуулаа л ардчилсан намын шинэчлэлийн төлөө, монгол орны ардчиллын төлөө гэсэн нэг зүгт зангидагдаж байна” гэв.



Гэрэл зурагч Т. АРГУУЖИН

## ЖОТГОН

Засгийн газраас явуулж буй үйл ажиллагаа, шийдвэрийн талаар ХНХ-ын сайд Н.Номтойбаяр хийлээ. Мэдээллийн эхэнд тэрбээр “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл (НДҮЗ)-өөс тэтгэвэр авах иргэн өөрсдөө үйлчлүүлэх банкаа сонгодог болох шийдвэр гаргасан. Үүнээс өмнө Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тэтгэвэрийг “ХААН” болон Төрийн банкаар дамжуулан олгодог байжээ. Харин иргэд тэтгэвэрээ хүссэн банкаараа авдаг арилжааны банкууд үйлчлүүлэгчээ татахын тулд шимтгэл, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, үйлчилгээгээ сайжруулах гэх мэтээр шударга өрсөлдөөний зарчимд шилжих ач холбогдолтой юм. Одоогоор 11 мянган иргэн тэтгэвэр авах банкаа сонгосон. Тэтгэврийн зээлийн хүүг 18 хувиас 15 болгож бууруулах шийдвэр өнөөдөр хэрэгжиж эхэлсэн. Эхний ээлжинд нийт тэтгэвэр авагчийн 91 хувь нь үйлчлүүлдэг “ХААН” болон Төрийн банктэй гэрээ байгуулж, хүүг бууруулсан. 1-6 сарын хугацаатай зээл авч байгаа тэтгэврийн зээлийн хүү 15 хувь болно. Харин одоо 18 хувийн хүүтэй зээл авчихсан иргэд зээлээ төлж дууссаны дараа шинээр зээл авахдаа 15 хувь руу шилжинэ. Улсын хэмжээнд 378 мянган иргэн тэтгэвэр авдаг. Шинээр тэтгэвэр тогтоох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх аян одоогоор хоёр аймаг, нэг дүүрэгт хэрэгжиж эхэлсэн. Өмнө нь би тэтгэвэр тогтоолгохын тулд хуурамч бичиг баримт бүрдүүлэх асуудал байдаг талаар байнгын хороод болон УИХ-ын чуулганы хуралдааны үеэр хэлж байсан. Аяны хүрээнд ч энэ асуудал үнэн гэдэг нь батлагдаж байна” гэлээ.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг арилжааны банкуудад есөн хувийн хүүтэй хадгалуулж байсныг 15 хувь болгох шийдвэр гаргасан байна. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдэл 557 тэрбум төгрөг. Уг мөнгийг есөн хувийн хүүтэй хадгалуулснаар улсын төсөвт төвлөрөх 30 тэрбум гаруй төгрөгийг алдаж байсан аж. Өөрөөр хэлбэл, НДС-ийн чөлөөт мөнгөн үлдэгдлээс 58 тэрбум төгрөгийн хүүг улсын төсөвт төвлөрүүлдэг байсныг 61.6 хувь буюу 36 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн юм байна. Түүнчлэн Гадаадаас ажиллах хүч авах, гадаадад

## БАЙНГЫН ХОРОО

## Төрийн ордонд засвар хийхэд 42.4 тэрбум төгрөг шаардлагатай гэв

УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан 14:20 цагт 52.6 хувийн ирцтэй эхэлж, хоёр асуудал хэлэлцэж шийдвэрлэж эхэллээ. Хурлын эхэнд Дипломат албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр тогтов. Үүний дараа “Төрийн ордны барилгын өнөөгийн төлөв байдлын дүгнэлт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах зарим арга хэмжээний талаар” Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын мэдээллийг сонслоо. Төрийн ордны барилгыг 1947 онд барьж эхэлсэн бөгөөд 1951 онд ашиглалтад оруулсан. Өнөөг хүртэлх хугацаанд хэд хэдэн удаагийн засварт орсон. Гэвч газар хөдөлтийн давтамж нэмэгдэж байгаа, мөн барилгын үндсэн тулгуур баганууд муудсан зэрэг нь аюулгүй байдлыг хангах боломжгүй болж ирж буй аж. Тиймээс Төрийн ордны барилгыг үе шаттайгаар буулгаж, дахин засварлах шаардлагатай гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагууд гаргажээ. Тухайлбал, Барилга хот байгуулалтын яамны гаргасан урьдчилсан тооцоогоор Төрийн ордны барилгын 1951, 1961 онд ашиглалтад орсон хэсгийг буулгаж, дахин барихад

ойролцоогоор 38.8 тэрбум төгрөг, 1981 онд баригдсан хэсгийг хучитган засварлахад 3.6 тэрбум төгрөг шаардах аж. Сайдны мэдээлэлтэй холбогдуулан байнгын хорооны дарга Ж.Энхбаяр Байнгын хорооноос тогтоол гаргаж Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзэж буйгаа турдаад Байнгын хорооны тогтоолын төслийг гишүүдэд танилцуулж санал хураалгахад хуралдаанд оролцсон 13 гишүүний 10 нь буюу 76.9 хувь нь тогтоолын төслийг батлахыг дэмжлээ. Тогтоолын төсөлд Төрийн ордны барилгыг хүчитгэх, шинэчлэн барих арга зам, шаардлагатай хөрөнгийн урьдчилсан тооцоо судалгааг гаргах, Төрийн ордны барилгыг шинэчлэн барих ажил хийгдэх үед түүнд байрладаг байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг ханган, өөр байранд түр шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулах, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах асуудалтай холбогдуулан төрийн дээд байгууллагуудыг нийслэлийн дагуул хот, суурьшлын шинэ бүсэд шилжүүлэн байрлуулах боломжийг судла, эдгээр асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулан УИХ-ын 2017 оны хаврын чуулганд оруулж шийдвэрлүүлэх чиглэлийг Засгийн газарт өгөхөөр тусгасан байна.

ажиллах хүч гаргах хууль анх 2001 онд батлагджээ. Энэ хуультай уялдуулаад Засгийн газрын тогтоол гарсан. Мөн 2015 онд 139 дүгээр тогтоолыг хүчингүй болгоод Засгийн газрын 41 дүгээр тогтоол гарсан байна. ХНХ-ын сайд Н.Номтойбаяр “Томоохон, үндэсний хэмжээний бүтээн байгуулалт, төмөр зам, цахилгаан станц гэх мэт ажилд дотоодоос ажиллах хүч гаргах бололцоогүй үед нарийн мэргэжилтэн, инженер техникийн ажилтан авах хүрээнд ажлын байрны төлбөрөөс чөлөөлдөг тогтоцоо үйлчлээд 16 жил болж байна. Үүнтэй уялдуулаад өөр бусад хөнгөлөлтийн асуудлыг Засгийн газар судалж байгаа. Ялангуяа эдийн засгийн хямралтай энэ үед томоохон бүтээн байгуулалт өрнүүлж байгаа аж ахуйн нэгж, компаниудын хуримтлагдсан татварыг дараа төлөх нөхцөлтэй гэрээ байгуулдаг байх гэх мэтчилэн дэмжлэг, хөтөлбөрүүдийг судалж байгаа” гэсэн юм.

Ийнхүү мэдээлэл хийний дараа зарим асуултад хариулт авлаа.

“Тэтгэврийн зээлийн хүүг хоёр банк бууруулж байгаа юм байна. Энэ хоёр банктэй ямар гэрээ хийж, ямар нөхцөлөөр бууруулж байгаа вэ?”

Ерөнхий сайдаас тэтгэврийн зээлийн хүүг шаг дараатай бууруул. Гэхдээ тэтгэвэр нэмэх боломжгүй байгаа өнөө үед санхүүгийн таатай ямар боломжууд байна үүнийг судалж, тодорхой шийдлийг танилцуул гэсэн үүрэг өгсөн. Үүний дагуу яам болон Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар ажиллаж байгаа. Одоо тэтгэвэр авагчийн 91 хувь нь Төрийн банк, “ХААН” банкаар үйлчлүүлж байна. Тэтгэвэр авагч өөрөө банкаа сонгодог боллоо. Одоогийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгосон зургаан мянга гаруй хүн өөрсдөө банкаа сонгосон бол урьд нь тогтоолгосон таван мянга гаруй хүн Төрийн банк, “ХААН” банкаас шилжиж, өөр банк сонгосон байгаа. Тэгэхээр аль банк нийт тэтгэвэр авагчдын хэдэн хувьд үйлчилж байна, тэрэнд нь Банкны тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийг удирдлага болгоод Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг тухайн зээлийн эргэлт, зээлийн багцтай нь уялдуулж байршуулж байна. Тухайлбал,

Төрийн банк, “ХААН” банканд 45 тэрбум төгрөг байршуулсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг 15 хувиас доошгүй байдлаар хадгаламж хэлбэрээр арилжааны банкуудад байршуулаа гэсэн шийдвэр гаргасан. Тэгэхээр тооцож байгаа 15 хувь, тухайн банктай маржинаа харилцан тохиролцоод, дөрөв болвол 11 хувиар, тав болвол 10 хувиар байршуулах замаар шийднэ. Одоогийн байдлаар хоёр банкинд 45 орчим тэрбум төгрөг байршуулсан байгаа.

“Хоёр банк сонгоод мөнгө байршуулж байгаа нь хуульд нийцэх үү?”

“Хууль зөрчиж байгаа зүйл өрсөсөө байхгүй. Тэглээ гээд зээлийн орлого буурсан уу гэвэл үгүй. 36 тэрбумаар нэмэгдсэн. Энэ сангийн орлогоос жилдээ дор хаяж 30 орчим тэрбум төгрөгийг орлогдох боломжтой гэж өнгөрсөн дөрвөн жилд хэлж байсан. Одоо тэрийг нөхөх шийдвэр гарсан.

“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг тэнэй яам хүлээн авдаг. Гэтэл танд хамааралтай компани нэлээд олон тэрбум төгрөгийн хөнгөлөлт авч байгаа. Энэ нь ашиг сонирхлын зөрчилтэй байгаа юм биш үү?”

“Би та хэдэд нэг зарчим ярьж. Монгол Улсад хийж бүтээж байгаа бүх аж ахуй нэгж компанийг дэмжинэ. 2015 оны хоёрдугаар сард гарсан Засгийн газрын 41 дүгээр тогтоол хүчин төгөлдөр үйлчилж байгаа. 41 дүгээр тогтоолтой танилц. Импорт орлох, экспорт луу чиглэсэн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дотоодоос ажиллах хүч авах бололцоогүй жишээ нь нарийн мэргэжил шаардсан нөхцөлд төлбөрөөс хөнгөлж байгаа юм. Ийм хөнгөлөлт авах боломж бүх аж ахуй нэгжид нээлттэй. Түүнээс биш “Монполимет” юм уу МАК-д үйлчлээд байдаг шийдвэр биш. Ямар номных нь ашиг сонирхлын зөрчил байдаг юм. Хуульд хөдөлмөрийн асуудал хариуцсан сайд шийднэ гээд заагаад өгчихсэн. Тэгэхээр надаас өөр хэн оруулж ирэх юм. Би ажлаа л хийж байна. Энэ хөнгөлөлтийн асуудал бол хоёрхон компанийнх биш. Давхардан тоогоор 200, давхардаагүй тоогоор 60 орчим компани байгаа. Зөвхөн

сүүлийн дөрвөн жилд 20 компани хамрагдсан. Цаашид нээлттэй. Хүсэлтээ өглөө, асуудлыг манай яам судалж үзлээ, бусад яамдуудаас саналаа аваад шийднэ. Яамдууд дэмжсэн тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар орж шийдвэрлүүлнэ. Одоогийн байдлаар хоёр компани хүсэлтээ өгч шийдсэн. Дахиад 4-6 компанийн хүсэлтийг судалж байгаа.

“Тэгвэл та бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Өөрөөр хэлбэл, монгол хүнийг чадавхжуулах үүрэг хүлээсэн гэсэн үг. Гэтэл хувийн компанидаа монголчууд хийж чадахгүй, нарийн мэргэжил шаардсан гэдэг шалтгаанаар гадны ажилтан авч байгаа нь хэр зохимжтой юм бэ?”

“Цементийн үйлдвэрийн барилгад барууны технологийг эзэмшиж, тэр үйлдвэрийг барих чадамжтай компани Монголд байхгүй. Хөтөллийн “Цемент шохой” үйлдвэртэй зүйрлэж болохгүй. Хөтөллийн монголчууд тариагүй. Хөтөллийн “Цемент шохой” үйлдвэр хэвтээ, хуурай технологи ашигладаг. Шал өөр. Эхлээд технологийн асуудлаа судлах хэрэгтэй. Дээр нь зөвхөн Хятадууд гэж яриад байх юм. Герман, Энэтхэгийн инженер техникийн ажилчид бий. Тэднийг ажиллуулснаар давхар монголчуудаа сургаж бэлтгэж байгаа юм.

“МАК компани хөнгөлөлт эдэлж байгаа нь УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүний хувьд хувьд хэр ёс зүйтэй асуудал вэ. Та бусдад үлгэр дууривал үзүүлдэг, хөнгөлөлт чөлөөлөгөөс татгалзах боломж байхгүй юу?”

“Та хэд өөрсдөө шүүн гунгаа. Энэ компани чинь Монгол Улсын төлөө бүтээн байгуулалт хийж байна. Ямар өнцгөөс асуудалд хандаж байгаа нь чухал. Тэгвэл цементийн үйлдвэр барихаа болиод Хятадаас жилд 120 сая ам.долларын цемент худалдаад авч л даа. Энэ үйлдвэр баригдвал 750 ажлын байр бий болно. Жилд 130 орчим тэрбум төгрөгийн татварын эх үүсвэр шинээр нэмэгдэж байгаа юм.

“Тэгэхээр та хөнгөлөлт авах нь зөв гэсэн байр суурьтай байна гэж ойлгож болох уу?”

“Зөв. Бүх компаниуд хөнгөлөлт авах эрх нээлттэй. Монголын төлөө хийж байгаа бүх компанийг хуулийн дагуу дэмжинэ. Үүнд МАК орно.

## МЭДЭЭЛЭЛ

## Ю.Цэдэнбалд зориулсан таван боть номын нээлт боллоо



Монголын төр, нийгэм, цэргийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, Маршал Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан “Хүмүүсийн дурсамж” гурван боть “Би тангарагтаа үнэнч байсан”, “Сүүлийн долоон жил” гэсэн таван номын нээлт боллоо. Нээлтэд ойт тэмдэглэн өнгөрүүлэх комиссын дарга, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат болон УИХ-ын гишүүд, “Ю.Цэдэнбал” сангийн

төлөөлөл оролцлоо. Нээлтийн үеэр ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат “Монгол Улсын түүхэнд хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн удирдагч бол Ю.Цэдэнбал дарга. Монголын төр засаг гүн хүндэтгэл үзүүлж өнгөрөгч онд хуулийн төсөл санаачлан баталж, Монгол Улсын Засгийн газар шийдвэр гарган Ю.Цэдэнбалын мэндэлсний түүхт 100 жилийг тэмдэглэн өнгөрүүлээ. Таван боть номын нээлтийг хийж байна. Их хүмүүний түүхт ойн хүрээнд олон арга хэмжээ зохион байгуулж, Монгол хүн бүр түүнийг дурсан санах үйл хэргийг нь өнөөдрийн залуус уншиж мэдэж суралцаж байна. Энэ жилдээ багтаан Ю.Цэдэнбалын гэр музей болоод түүхэн уран сайхны кино бүтээхээр боллоо” гэсэн юм. Гэр музей байгуулах гэж байгааг “Ю.Цэдэнбал” Академийнхан энэ үеэр хэлж байлаа. 100 жилийн хүрээнд “Маршалын нууц товчоон” номын эхний дэвтрээ, “Монгол цэргийн нэрт зүтгэлтэн Маршал Ю.Цэдэнбал” зэрэг ном мөн хэвлэгдэн гарсан байна.

**МЭДЭЭ**

## Хоол ундаа зохицуулж чадахгүй байж яаж төрийн ажил хийх юм бэ

МҮОНТ-д сэтгүүлчээр ажиллаж олны танил болж байсан сэтгүүлч М.Оюунчимэг УИХ-ын гишүүн гэх эрхэм дээд суудалд залраад байгаа. Тэрбээр нэгэн үе ММ агентлагийн захирлаар ажиллаж байсан ч МҮОНТ-ийн захирал Ц.Оюундаруу түүнийг ажлаас нь халж “лааз өшиглүүлж” байсан юм. Гэсэн хэдий ч өнөөх ажилгүй бүсгүй маань аз од нь гийсэн “бор халзан хонинуудын” нэг болсон. Төрийн

ордноос улс төрийн мэдээг шууд дамжуулж, олонд танигдсан сэтгүүлч М.Оюунчимэгийг энэ удаагийн парламентад суугаа бусад эмэгтэй гишүүдээс арай дөнгүүр нь гэж тоох хүн олон байсан. Гэтэл тэрбээр төрийн бодлого батлуулахад түүч ч хэрэггүй хүмүүсийн нэг гэдгээ батлах гэж байгаа мэт Төрийн ордонд байнгын хорооны хурал дээр хооллож байгаа бүдүүлэг бичлэг нь олныг бухимдуулаад авлаа. Уг нь эрхэм гишүүдэд

хурлын дундуур хоол, цайгаа уух зорилгоор суугаа цагтай байдаг. Гэтэл тэрбээр байнгын хорооны хурал дээр гялгар цаас шажигнуулаад хэвнэг “хэвээд” сууж байгаа нь өөрийгөө хэн, хаана байх ёстой хүн гэдгээ батлаад байна уу даа. Монголын эмэгтэйчүүд ч үр бүлээ байтугай улс орноо авч яваа гэтэл энэ хэдэн эмэгтэй гишүүн өөрийгөө ч авч явж чадахгүй юм даа. Хоол ундаа зохицуулж чадахгүй байж яаж төрийн ажил хийнэ дээ.


# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

Дугаарын **60** мөр

## Золбин ноход зоолж байна

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт



УЦХ-ын гишүүн  
**Х.Нямбаатар**

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Ийн хэлэх учир нь мэргэжлийн Засгийн газар байгуулна гэсэн сайхан амлалт нь дашин шог болж, “бөгс удаан” бүдүүн бүлэг гэх шүүмжлэлийн бай болоод буй эрх баригч МАН-ын унхиагүй байдлаас ард түмэн аль хэдийнэ залхаад эхэлчихлээ. Үнэмлэхүй олонхи болж чадаагүй ч засагласан дөрвөн жилдээ АН-ынхны бүтээн байгуулсан, хийсэн ажлыг нь ард түмэн үгүйлж байна. Тиймээс сөрөг хүчин болсон Ардчилсан намын даргын дотоод сунгааг 2020 оны Ерөнхий сайдын төлөөх сонгууль юм шүү гэж тайлж уншихад буруудахгүй. Урьдын адил фракциудын тохироогоор сонгох юм бол “де-факто” явсаар дараагийн сонгуультай энэ байдлаараа л золгоно. Энэ бол сургамж. Одоо АН-д элдэв хаяггүй, “малгай”-гүй дарга хэрэгтэй. Хамгийн чухал нь зангараг. Хэн нэгний халаасагц багтдаг, өөрийн гэсэн бодлогогүй, сулбагар Ерөнхий сайд ямар байдгийг, гүйцэтгэх засаглал эзэнгүй юм шиг явагч өөрсдийнхөө сонгосон харалган сонголтоос харж, үзэж халаглаж суна. Тиймдээ ч бусдад худалдагдахгүй, бусдын үг үйлдлээр явахгүй, “утсан хүүхэлдэй” болохгүй тийм л хүнийг АН даргаар тавьж, дараагийн Ерөнхий сайдыг бэлтгэх учиртай юм. 170 мянган хүнийг удирдах төдийхөн явцуу хүрээнд сонголт хийж болохгүй гэсэн үг, АН-ын гишүүд. Харин тэр хүн хэн бэ? Мэдээж орон даяар өрнөж буй дотоод сунгаанд нэр дэвшсэн тавын нэг байж таараа. Намын даргаа гишүүдийнхээ саналаар тодруулах энэ сонгуульд үйл явц улс төрийн намуудын түүхэнд цоо шинэ жишгийг бий болгож өглөө. Даргыг цөөхөн хэдхэн хүн суугаад томилдог бус намын жирийн гишүүдийн итгэл үнэмшлээр сонгодог шинэ жишиг улс төрийн намуудын түүхэнд тодоор бичигдэх үйл явц гэдгийг үгүйсгэж боломгүй. Үүнийг ч нэр дэвшигчдийн зарим нь онцлон хэлж байгаа билээ. Нөгөө талаас ажвал энэ удаагийн сунгааг тэдний хэн нь хэн бэ гэдгийг илүү тод томруун харуулж байна.

### Төрийг “түүхий хүн”-ээр удирдуулах вий

Нэр дэвшигчид дунд олон янзын хүсэл сонирхлоор дарга болох амбиц нь хөдөлсөн хүмүүс явж байгаа. Нэр дэвшигчдийн дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр, өгч буй амлалтаас харахад өөр өөрийн гэсэн имижийг бүрдүүлэх гэж хичээж, дотоод итгэл үнэмшил, янз төрх нь үг үйлдлээс нь ялгарч, зарим

# АРДЧИЛСАН ТӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙГ АВРАХ СОНГОЛТ ХИЙГЭЭРЭЙ, АН-ЫНХААН



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

талаараа зөрчилдөж эхлэх болов. Танигдахын аргагүй өөрчлөлт бялуурсан ерөөл магтаал, байж ядсан хүсэл ч харагдаж байгааг нуугаад яахав. Тухайлбал, зарим нь Ардчилсан намын шинэчлэл бол шинэ үеийнхэн удирдлагын түвшинд гарах ёстой гэсэн ойлголтыг олон нийтэд төрүүлэхийг зорьж байгаа. Гэхдээ шинэ үе гэж ганцхан насны ялгааг хэлэхгүй. Тэр тусмаа хуучин “зам”-аар, халаасны залуу хүн явахыг энэ намд залуу үе хэрэгтэй гэсэн “жижигхэн” амбицаар сонголт хийх нь утгагүй хэрэг. Намын ажлын алдаа, оноо алинаас нь ч хол хөндий явсан хүн жирийн гишүүд дотроо орж ажиллаж чадна гэдэг бараг л үлгэрийн гэмээр ойлголт. Нэг үгээр хэлбэл, намын гал тогоог ч удирдаж үзээгүй “түүхий хүн”-ээр төрийн гал тогоог удирдуулж, бодлогын алдаа оноог дэнсэлнэ гэдэг нь хийж болох хамгийн буруу сонголт болно. Улс төрд суралцаж яваа залуу үеэр улсынхаа ажлыг самруулах сонголтыг АН-ын 170 мянган гишүүн хийхгүй гэдэгт итгэж суна. Ардчилсан намын

даргын сунгаа үе солих тухай улиг болсон пиараас ангид болох учиртай. Монголчууд нэг үеийг бодоход тун ч ухаалаг болсон. Хэн нь ард түмний төлөө чин сэтгэлээсээ дуугарч, ажиллаж, хэн нь зүгээр л эх оронч хэмээн цээжээ дэлдэхээс хэтрэхгүй явааг ялгаж салгадаг болсон. Тэр тусмаа ардчиллын үнэ цэнийг энх тайвныг газрын өндөр сэнтийд суулгах гэж ардчиллын төлөө тэд өглөө үдэшгүй жагсаал хийж суугаагүй нь лавтай. Ардчилал ялсан, ялагдсан, унасан боссон үед нэг л зангаараа явсан үнэнч гишүүдийн сонголтод замын дундаас орж ирсэн хэн нэг попчин нөхөр нөлөөлөх гэж оролдох нь өөрөө увайгүй хэрэг юм. Дүр эсгэх, дарга болохын төлөөх адын хүсэл хэзээд сайн зүйл дагуулдаггүй бид үе үеийн төрд байсан, байсаар байгаа олон олон “поп”-чидын үнэн төрхөөс харсан, бас залхсан. Нэгэн цагт бидэнд сайхан харагдаж байсан хийрхэл, хий хоосон амбиц, популист урна лоозон өнөөдөр ямар ч хэрэггүй зүйл байсныг ойлгож эхэлсэн нь сайшаалтай хэрэг.

### Ардчилал хэн нэгнийг хамгаалах бамбай биш

Нобелийн энхтайваны шагналт, удирдагч Ан Сан Су Чи Монголд ирэхдээ “Дүр эсгэсэн ардчилал дарангуйллаас илүү хортой. Нийгмийн гажуудлыг засахгүй байх шалтгаан болдог” хэмээн хэлсэн байдаг. Ардчилсан төрийн үнэлэмж унаж буйг хамгийн тод томруунаар олж харсан энэ дүгнэлт буруу байгаагүй. Тэгвэл ардчилал өдгөө хэн нэгнийг хамгаалах бамбай, хоргодох байр болон хувирах нь уу гэсэн болгоомжлол ч энэхүү сунгааг ажиг суухад төрснийг нуух юун. Ах дүү, амраг саднаараа хууль хяналтад чихдүүлчихээд ардчилал намайг хамгаалах ёстой хэмээн амь эрж явагч олон удаагийнх нь үг үйлдлээс дүгнэж болохгоор байна. Зарим нэр дэвшигчид хатуу ч гэсэн үүнийг сонсох, үнэнтэй нүүр тулгарах цаг нь болсон. Ардчилсан Ерөнхийлөгчийн хэлдэгчлэн хууль чамайг дуудахад гутлаа өмсөөд, оймсоо углаад очих ёсгүй байх хэрэгтэй юм. Түүнээс биш дарга болж амиа хоохойлж, бөөлжсөн бөөлжсөө эргэж долоох нь увайгүй үйлдэл. Ардчилал олон хүнд буян болсон. Дугуугаа гүйцээж дундуураа дүүргэх боломжийг өгсөн. Гэвч тэд ардчилалдаа буян болсон уу гэдэг асуултад харамсалтай нь хариулт алга. Амны

алдаа бүр нь ардчиллын алдаа болж харагддаг, тогтворгүй харц, тэнэмэл үг нь ардчиллыг муухай харагдуулдаг сонголтыг нэг биш удаа хийж үзсэн. Эцсийн дүнд нь их ялагдал байсныг мартаж учиргүй юм. Орон шоронд орж явахад ардчилал намайг хамгаалаагүй гэх өс санасан сэтгэл өвөрлөсөн хүмүүс ч энэ сунгаанд явж харагдах аж. Өс өвөрлөсөн намаа өөрийн гэсэн сэтгэлээр удирдаж чадах уу гэх зөрүүд хүсэл ч төрж байгааг нуугаад яахав. Худал хуурмаг, хулгай луйвартайгаа ардчилал зууралдсаар л байвал 2020 онд дахиад л лаазаа өшиглөнө. Фракцийн улс төрөөсөө ангижирч чадахгүй, дансны аргаар дарга болох гэсэн луйварчдад боломж олгох тусмаа энэ нам түүхээс арчигдах эхлэлээ тавина гэсэн үг. Өнөөдөр нэг “жижигхэн” намын даргыг дансны аргаар авсан хүн маргааш ард түмнээ дансны аргаар луйвардахгүй гэх баталгааг хэн өгөх юм бэ. Хатуу боловч үнэн ийм л байна. Ардчилсан төрийн үнэлэмжийг унагахад гар бие оролцож явсан атлаа ардчилсан төр байгуулаад удирдаж чадна гэсэн итгэл үнэмшил хэнд төрөх билээ. Надад лав төрөхгүй нь. 2016 онд намаа ялагдаулсан хүн эдгээр таван нэр дэвшигчид дунд нэг биш нэлээд хэд бий шүү. Ялагдаулсан намаа дахиад ялалтад хүргэнэ гэсэн итгэл огтоос ч төрөхгүй нь, уучлаарай. Миний ижил бодол АН-ын мянга мянган гишүүдэд төрж байгаа. Ардчилал олон удаа алдсан. Харин алдаагаа дахин давтах учиргүй. Ардчилсан намын гишүүд алдах ёсгүй сонголт хийх хэрэгтэй болж байна. Зөв сонголт маргаашийн засаглалын хямралгүй төрийг бий болгох эхлэл болно. Харин тэр сонголт АН-ын 170 мянган гишүүний үзэргийн хошуугаар шийдэгдэх учиртай юм. Монгол төрд үеийн үед үгүйлэгдэж байгаа ноён нуруу, үнэнээ нүүр буруулагдгүй шударга ард түмний хүсэл үүрд нээгдэнэ, эсвэл үүрд хаагдахыг надаар хэлүүлэх юун. Зөв сонголтыг хийж чадахгүй бол хувьсгалын үйл хэрэг хэмээн цэвжээ дэлдэх атлаа хуу хамж идчихээд улсаа дампууруулж суугаа МАН-ын бүдүүн бүлэгтэйгээ маргааш ч гэсэн зууралдсаар суух биз ээ. Тийм цаг үе битгий ирээсэй хэмээн залбирч сууна. Тэгэхийн тулд ардчиллын мянга мянган гишүүд мэргэн сонголт хийгээсэй хэмээн хүсч, хүлээж сууя даа.

Бодит байдал ийм л байна. Өмнө нь золбин нохойтой тэмцэх ажлыг “Нөөц” гэдэг компани гардан гүйцэтгэж байсныг 2014 оны дөрөвдүгээр сараас нийслэлийн есөн дүүргийн Засаг даргын Тамгын газар хариуцдаг болж байсан. Үүний дараахан золбин нохой, муур устгах ажлыг “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ давхар зохион байгуулж эхэлсэн. Тэгээд ч үр дүнд хүрсэнгүй. Золбин нохой, муур устгах зардал 7500 төгрөг байсан бөгөөд энэ зардал хүрэхгүй байна гэсээр байгаад 12 мянган төгрөг болгож нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Ингэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хотын төвд нохой муурыг буудаж устгалгүйгээр иргэдээс тодорхой хэмжээний ханшаар худалдан авах, уургалан бариад нэг цэгт тээвэрлэн хүргэж устгалд оруулах гэх мэт зохион байгуулалтын ажлуудыг хийх шаардлагатай гэж байсан. Тэгвэл энэ ажил яв аа. Үүнээс гадна золбин нохойны асуудал хөндөгдөхөд спираль тавих гэж байгаа гээд л бөөн юм болсон. Энэ асуудал олон нийтийн цахим сүлжээгээр нэг тарж, шүүмжлэлд өртсөөр эцэстээ таг болсон. Бас болоогүй төрийн зарим чиг үүргийг төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуур гүйцэтгүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас эзэнгүй золбин нохой, муур устгалын гүйцэтгэлд хяналт тавих, түүнтэй холбогдох судалгаа, мониторинг хийх ажлын саналыг төрийн бус байгууллагуудын дунд зарлаж, сонгогдсон төрийн бус байгууллагууд эзэнгүй нохой, муур устгах ажлыг газар дээр нь биечлэн шалгаж, устгагдсан нохойны тоо хэмжээг тогтооно. Мөн устгасан нохой, муурны сэг зэмийг шатаах ажлыг шалган тоон судалгааг гаргана. Судалгааны ажлын хүрээнд эзэнгүй нохой, муурны тархалтын судалгааг гаргаж, тухайн бүсийг хариуцсан устгалын байгууллагад мэдэгдэж, гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд шаардлага тавьж устгал хийлгэнэ гээд л байна. Золбин нохой муурыг устгах талаар дэвшилтэт арга технологи, санал, санаачилгыг судалж, 2016 оны гуравдугаар сарын 01-нээс 2017 оны гуравдугаар сарын 01 хүртэл гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа л гэж байсан. Гэтэл өнөөдрийг хүртэл таг. Бодвол өнөөх судалгааныхаа ажлыг хийгээд завгүй байгаа юм байлгүй. Тэднийг судалж тогтоогоод, мониторинг хийж суусаар байтал өнөөх золбингууд чинь зоолж, хавартай зэрэгцэж ороо нь ороод, харин ч нэг өсөн нэмэгдэж байлгүй. Өнөөх “Аз жаргалтай хот”-доо иргэдээ амгалан тайван явуулж, элдэв халдварт өвчнөөс сэргийлэхийн тулд золбин нохойн устгалыг хийж, хотоо цэвэршүүлээр байна. Төрийн хамгаалалтад авах гээгүй л юм бол арга хэмжээ аваач.

# ДЭЛХИЙ

# ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ОЛОН УЛСЫН ШҮҮХЭД ӨГӨВ



### Үргэлжлэл. Түүрүү нь I нүүрт

Өмнө нь Украины төрийн тэргүүний албан ёсны сайтад “ОХУ нь Украины эсрэг хүчирхийлэл үйлдэн Крымыг эзэмшиж, Хар тэнгис, Азовын тэнгисийн сав газарт манай улсын байгалийн нөөцийн эрхийг зөрчиж байна” хэмээн бичсэн байсан бөгөөд үүний дараа Крымын зүгээс харну мэдэгдэл хийж, эсрэгээр Украиныг НҮБ-д өгөхдөө бэлтгэж буйгаа дуулгаж байсан юм. Тодруулбал, “Украины бүрэлдэхүүнд тус хойг орсон үеэс л хүний эрх зөрчигдөж байсан талаар тогтоолын төсөл бэлэн болгоод НҮБ-д өгөхөөр бэлтгэж байна” гэж мэдэгдсэн удаатай. Крымын Олон улсын харилцаа болон нүүлгэн шилжигсдийн асуудал хариуцсан улсын хорооны тэргүүн Заур Смирнов “Энэ баримтад тус хойг Украины эзэмшилд байх үед Крымын татаруудыг эргүүлэн авчрах үеэр хүний эрхийг хэрхэн зөрчиж байсныг, 2014 онд Украинд төрийн эргэлт хэрхэн гарсан талаар тодорхой тусгасан” гэжээ. ОХУ-ын Хүний эрх, ардчилал болон дээд эрхийн бүрэн эрхт

төлөөлөгч Константин Долгов 2016 оны арванхоёрдугаар сард “Украин бол хүний эрхийг зөрчиж байгаа ганц улс” гээд тус улс “Үндсэрхэг үзэлтний хүчирхийлэл, үндэсний хэт даврах үзэл, цэрэгжсэн гүрэн” болж “хүний эрх, ардчиллын салбарт туршилт хийж байна” гэж мэдэгдсэн юм. Харин энэ удаа Олон улсын шүүх Украины талын нэхэмжлэлтэй ОХУ-ын эсрэг гомдол ирснийг баталгаажуулан олон нийтэд мэдэгдсэн нь энэ. Украины зүүн этгээдэд 2014 оноос хойш салан тусгаарлах сонирхол бүхий ОХУ-ын талыг дэмжигч босогчид болон Украины Засгийн газрын армийн хооронд ширүүн дайн өрнөж

эхэлсэн байдаг. Сөргөлдөгч талууд гал зогсоох хэлэлцээрт хэдэнтэй тохиролцоонд хүрсэн ч, аль аль тал удаа дараа зөрчсөний улмаас хамгийн сүүлд авсан мэдээгээр 10 мянга орчим хүн нас баржээ. ОХУ-ын хувьд босогчид зэвсэг, техникийн тусламж үзүүлсэн гэдгээ эртнээс үгүйсгэж ирсэн юм. Тиймдээ ч Украины талын Олон улсын шүүхэд гомдол гаргаж, нөхөн төлбөр шаардсан явдлыг “Улс төрийн ашиг хонжоо олох зорилготой ажиллагаа” гэх үзэж буйгаа илэрхийлсэн байна. Түүнчлэн, ОХУ-ын Гадаад хэргийн яамны мэдэгдэлд “ОХУ ямар нэгэн терроризмын үйл хэргийг үргэлж буруушааж, эрчимтэй тэмцэх болно” гэсэн байв.

## Дэлхийн хамгийн “үл таалагдах” рейтингтэй Ерөнхийлөгч Доналд Трамп

Маргааш Ерөнхийлөгчийн тангаргаа өргөх Доналд Трампын талаар ABC телевиз олон нийтийн санал асуулга явуулжээ. Улмаар судалгаанд оролцогчдын ердөө 40 хувь нь л Д.Трампын Ерөнхийлөгчийн албан тохирох хүн гэж үнэлсэн бол 54 хувь нь эсрэг хариултыг сонгожээ. Ингэснээр сүүлийн 40 гаруй жилийн түүхэн дэх хамгийн “үл таалагдах” рейтингтэй Ерөнхийлөгчөөр Д.Трамп нэрлэгдэж байна. Тус телевиз шинэ Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолоос урьтаж, энэсарын 12-15-ны өдрүүдэд олон нийтийн санал асуулгыг зохион байгуулж, дүнг нь өчигдөр зарласан юм. Гэтэл Трампыг Ерөнхийлөгч болсонд санал асуулгад оролцогчдын ердөө 40 хувь нь таатай сэтгэгдэлтэй байгаа бол эсрэгээр 54 хувь нь “Огт таалагдахгүй” байгаагаа илэрхийлжээ. Иймд шинэ Ерөнхийлөгчийн рейтинг 1977 оноос хойшхи хамгийн муу үзүүлэлт болж байна. Харин ард түмний дунд хамгийн рейтинг өндөртэй Ерөнхийлөгчөөр Барак

Обама нэрлэгджээ. Найман жилийн өмнөх санал асуулгаар түүнийг дэмжигчдийн хувь 79 байсан аж. Нөгөөтэйгүүр, судалгаанд оролцогчдын 61 хувь нь Доналд Трамп оновчтой шийдвэр гаргаж чадах эсэхэд санаа зовж буйгаа илэрхийлсэн бол 52 хувь нь Ерөнхийлөгчийн албан тушаалд тэнцэхгүй гэж хариулсан байна. Харин 60 хувь нь Д.Трампын эдийн засаг, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээрх бодлогыг дэмжсэн бол 56 хувь нь терроризмын эсрэг бодлогод нь өндөр үнэлгээ өгсөн гэнэ. Тэгвэл санал асуулгын дүн нийтэд зарлагдсаны дараа сошиал сүлжээний идэвхитэй хэрэглэгч болох Д.Трамп ч харну мэдэгдэл хийгээд амжжээ. Тэрбээр өөрийн албан ёсны твиттер хуудастаа “Сонгуулийн сурталчилгааны үеэр ташаа, луйврын санал асуулга явуулж байсан хүмүүс энэ удаа ч Ерөнхийлөгчийн рейтингийн судалгааг явуулжээ. Өмнөхтэйгөө л ижил заливангийн судалгаа” гэж жиргэсэн байна.



## Хөлбөмбөгийн тамирчныг террористын жагсаалтад оруулжээ

Египетийн шүүх хууль бус лалын шашины байгууллага болох “Мусульман ахан дүүс”-д санхүүгийн дэмжлэг үзүүлсэн гэх шалтгаанаар хөлбөмбөгийн тамирчин Мохамед Аботрика террористуудын жагсаалтад нэмжээ. Энэ талаар тамирчны өмгөөлөгч мэдэгдсэн байна. Нэгэн цагт хөлбөмбөгийн зүлэг ногоон дэвжээнд гарч, од болон гялалзаж явсан ч, эдүгээ их спортын орхисон Мохамед Аботрикагийн хөрөнгийг царцах шийдвэрийг зодог тайлснаас нь хоёр жилийн дараа буюу 2015 онд Засгийн газраас гаргаж байсан аж. Тэрбээр Египетийн Аль Ахли клубт харьяалагдаж, улсаа төлөөлөн тоглодог байв. Японд зохиогдсон “FIFA Club World Cup” тоглолтод ч оролцож байжээ. Тус улсын Засгийн газрын хувьд нэрт хөлбөмбөгчдийг 2013 оны сүүлчээр “Мусульман ахан дүүс” террорист байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хэрэгт буруутгаж буй гэнэ. Египетийн Ерөнхийлөгч Абдел Фаттах аль Сисигийн 2015 онд санаачилсан Терроризмын эсрэг хуульд зааснаар террористын жагсаалтад багтсан эрхмийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахаас гадна, паспортыг нь хурааж, эд хөрөнгийг нь царцах арга хэмжээ авдаг байна. Мохамед Аботрика тухайн үеийн Африк гаралтай хөлбөмбөгчид дундаа хамгийн амжилттай явсан тамирчдын нэг байсан бөгөөд 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Мохамед Морсиг дэмжиж байжээ.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 19  
Тендер шалгаруулалтын нэр: УБХИС, ЦТЭ-ийн шатахуун нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: БХЯ/201700003

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ эрх бүхий тендерт оролцогчдоос шатахуун нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:  
Борлуулалтын хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлшин хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 1,150,512 төгрөг, 2-р багцад 1,715,440 төгрөг, 3-р багцад 408,035 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 14.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байшлуудан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 14.30 цагт дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.  
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮТ-ын Хаан банкн дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.

*Баянзүх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г.Хандмаа*

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 19  
Тендер шалгаруулалтын нэр: УБХИС, ЦТЭ-ийн хэрэгцээт эм, ороох боох материал нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: БХЯ/201700004

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ эрх бүхий тендерт оролцогчдоос эм, ороох боох материал нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:  
Борлуулалтын хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлшин хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 792,340 төгрөг, 2-р багцад 322,265.40 төгрөг, 3-р багцад 618,802 төгрөг, 4.1-р багцад 1,283,177.50 төгрөг, 4.2-р багцад 52,971.40 төгрөг, 4.3-р багцад 68,541.50 төгрөг, 5-р багцад 467,088.50 төгрөг, 6-р багцад 297,380.50 төгрөг, 7.1-р багцад 549,322.50 төгрөг, 7.2-р багцад 299,657 төгрөг, 8-р багцад 543,080.10 төгрөг, 9-р багцад 699,204.50 төгрөг, 10-р багцад 1,230,578.75 төгрөг, 11-р багцад 436,079.38 төгрөг, 11.1-р багцад 5,837.50 төгрөг, 12-р багцад 44,175 төгрөг, 13-р багцад 130,917.50 төгрөг, 14-р багцад 539,412.50 төгрөг, 15-р багцад 687,125 төгрөг, 16-р багцад 270,537.50 төгрөг, 17-р багцад 698,050 төгрөг, 18-р багцад 555,348.75 төгрөг, 19-р багцад 271,017.50 төгрөг, 20-р багцад 718,990.75 төгрөг, 21-р багц 150,151.60 төгрөг, 22-р багцад 722,261.25 төгрөг, 23-р багцад 438,076.50 төгрөг, 24-р багцад 40,920 төгрөг, 25-р багцад 89,884.50 төгрөг, 26-р багцад 74,415.50 төгрөг, 27-р багцад 2,135,695.40 төгрөг, 28-р багцад 64 төгрөг, 29-р багцад 90,115.20 төгрөг, 30-р багцад 64,821.75 төгрөг, 31-р багцад 10,342.50 төгрөг, 32-р багцад 43,285.20 төгрөг, 33-р багцад 222,264 төгрөг, 34-р багцад 136,416 төгрөг, 35-р багцад 164,646.20 төгрөг, 36-р багцад 62,496 төгрөг, 37-р багцад 71,634.15 төгрөг, 38-р багцад 37,672.95, 39-р багцад 1,274,385, 40-р багцад 41,909 төгрөг, 41-р багцад 1,494 төгрөг, 42-р багцад 44,560 төгрөг, 43-р багцад 14,158 төгрөг, 44-р багцад 3,947 төгрөг, 45-р багцад 11,634 төгрөг, 46-р багцад 12,008.80 төгрөг, 47-р багцад 25,512.30 төгрөг, 48-р багцад 17,875.44 төгрөг, 49-р багцад 11,583 төгрөг, 50-р багцад 13,620.56 төгрөг, 51-р багцад 9,373.48 төгрөг, 52-р багцад 52,488.64 төгрөг, 53-р багцад 46,636 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 15.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байшлуудан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 15.30 цагт дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.  
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮТ-ын Хаан банкн дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.

*Баянзүх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮТ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г.Хандмаа*

"КЛОВЕР" ХХК, БЭСБ АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРИЙН ТАЙЛАН 2016 оны 12-р сарын 31				"КЛОВЕР" ХХК, БЭСБ АУДИТЛАГДСАН БАЛАНС 2016 оны 12-р сарын 31				"КЛОВЕР" ХХК, БЭСБ АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 2016 оны 12-р сарын 31			
				(төгрөг)							
				ХӨРӨНГӨ							
				тэмдэглэгээ							
				2015.12.31				2016.12.31			
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт				202,120,000.00		202,120,000.00					
Хуримтлагдсан ашгийн бууралт				(301,003,373.41)		(301,003,373.41)					
Тайланг үеийн цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл				2,099,103,373.41		2,441,185,734.14					
Хуримтлагдсан ашгийн бууралт				(301,003,373.41)		(301,003,373.41)					
Тайланг үеийн цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл				2,099,103,373.41		2,441,185,734.14					
Нийт хөрөнгийн дүн				2,115,412,246.94		2,765,091,556.54					
Өр төлбөр											
Болоно хугацаат өр төлбөр											
Итгэлцлийн үйлчилгээний өглөг				10,000,000.00		310,220,756.52					
Татварын өглөг				6,308,873.53		13,685,065.88					
Нийт Болоно хугацаат өр төлбөр				16,308,873.53		323,905,822.40					
Урт хугацаат өр төлбөр											
Нийт өр төлбөрийн дүн				16,308,873.53		323,905,822.40					
Эзний өмч											
Эзний өмч				1,798,100,000.00		2,000,220,000.00					
Хуримтлагдсан ашиг				301,003,373.41		440,965,734.14					
Эзний өмчийн дүн				2,099,103,373.41		2,441,185,734.14					
Эзний өмч ба өр төлбөрийн дүн				2,115,412,246.94		2,765,091,556.54					
Борлуулалтын орлого											
Үндсэн үйл ажиллагааны нийт орлого				878,804,050.00		878,804,050.00					
Хүүгийн зардал				(1,150,000.00)		(1,150,000.00)					
Нийт ашиг				877,654,050.00		877,654,050.00					
Үндсэн үйл ажиллагааны зардал				(3,336,348.00)		(3,336,348.00)					
Үндсэн үйл ажиллагааны ашиг				874,317,702.00		874,317,702.00					
Үйл ажиллагааны бус үйл ажиллагааны орлого				306,390,152.41		306,390,152.41					
Үйл ажиллагааны бус үйл ажиллагааны зардал				(1,850,000.00)		(1,850,000.00)					
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал				304,540,152.41		304,540,152.41					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					
Тайланг хугацааны ашиг											
Татварын зардал				(13,685,065.88)		(13,685,065.88)					
Цэвэр ашиг				440,965,734.14		440,965,734.14					

# ОНЦЛОХ ХУУДАС

## Өүгү тү өүгү аү?

# ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН ХЭН НЬ ХЭН БЭ



### Гадаад харилцааны яам - Даминсүрэнгийн ДАВААСҮРЭН

Гадаад төрх байдлаараа улс төрд харьцангуй залуу хүн мэт харягддаг энэ эрхэм улс төр хийгээд дипломат албанд 20 гаруй жил зүтгэж яваа нэгэн. Ажил мэргэжлийн онцлогоос хамаарч ил гарахгүй л байсан болохоос биш. Улс төрийн хүрээнийхэн түүнийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад нэрийг нь дэвшүүлсэн тухай яригдаж эхлэхэд М.Энхболдын хүн гэх мэдээллийг нийгэмд цацсан. Үнэндээ ч тэрбээр УИХ-ын дарга М.Энхболдыг МАН-ыг удирдаж эхэлсэн үеэс Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын даргаар нэг хэсэг ажиллаж байсан билээ. Гэсэн хэдий ч Д.Даваасүрэн мэргэжлийн дипломатч. БНМАУ-ын ЗХУ-д энэ чиглэлээр бэлтгэсэн боловсон хүчинүүдийн нэг. Москвагийн ОУХДС-ийг 1995 онд төгссөн тэрбээр ГХЯ-ны Ёслолын хэлтэс ажил амьдралынхаа гарааг эхэлж, Олон улсын байгууллагын газарт агаашаа, Улс төрийн газар, Ази-Америкийн газарт III дугаар нарийн бичгийн дарга, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яаманд Хоёрдугаар, Нэгдүгээр нарийн бичгийн дарга, Консулын хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай. Мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн тухайд ч хүний өмнө бариад зогсох хавтас түүнд бий. Олон улсын эдийн засагч, дипломатчийн дипломаас гадна эдийн засгийн ухааны магистр болон Олон улсын бизнесийн удирдлагын магистр цол хамгаалсан тухайгаа намтартаа онцолсон байна лээ. Эхнэр гурван хүүхдийн хамт амьдардаг. Улаанбаатар хотын уугуул. 1970 оны гал нохой жилд төрсөн дипломатч.

### Хууль зүй, дотоод хэргийн яам- Г.БАЯСГАЛАН

Хуульч Г.Баясгалан гурав дахь удаагаа Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна. Монголын төрд төрийн өндөр албан тушаалыг гурвантаа хашсан эрхэм түүнээс өөр үгүй ч байж мэднэ. Түүнд атаархсан улс төрийн хүрээнийхэн хийгээд өрсөлдөгч нар нь "МАН төр барьж байх аваас энэ эрхэм ийм зиндааны албан тушаалд суух нигуртай ажээ" гэх үгийг УИХ-аас Төрийн нарийн бичгийн дарга нарын нэрийг зарлах үед унагаж л байсан. Нөгөөтэйгүүр, УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж түүнийг тоож, улс төрд оруулж ирсэн гэх яриа байдаг. Үнэндээ ч мань хоёр улс төрд дотно харьцатай. Хэн хэнийхээ үгийг сонсдог гэж хэлж болно. Д.Нямдорж сайдаар томилогдсон даруйдаа Төрийн нарийн бичгийн даргаараа мань эрийг томилсон нь бий. Гэхдээ эл томилгоо яамны хувьд ч, сайдын хувьд ч алдаа болоогүй. Хууль зүйн салбарын шинэчлэлд энэ хоёр эрхмийг хамтдаа санаачилсан, эхлүүлсэн, ард нь гарсан ажлууд зөндөө. Г.Баясгалангийн тухайд ч намдаа түшиг тулгуур, нөмөр нөөлөг нь болдог эртэй, чадалтай боловсон хүчинүүдийнх нь нэг. Москвагийн их сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн тэрбээр төрийн мэргэшсэн албан хаагч бөгөөд хуульч мэргэжилтэй, хууль зүйн ухааны доктор, төрийн захиргааны

тэргүүн түшмэл, хууль цаазны итгэмжит төлөөлөгч юм. Урьд нь Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, зөвлөх, Хууль зүйн яамны газрын дарга, Хууль зүй Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх зэрэг олон хариуцлагатай албыг хашиж байсан билээ. Тодруулбал, Ерөнхийлөгч асан Н.Багабандид шадарлаж явсан хэрэг.

### Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам- А.БАЯРТУАГА

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртуулгыг Сү.Батболдын хүн гэх. Эл мэдээллээс улбаалж, намтар түүхийг нь сонирхох аваас тэрбээр Сү.Батболдын Засгийн газрын үед яамныхаа Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан тухайгаа бичжээ. Олон улсын эдийн засагч мэргэжилтэй энэ эрхмийн өмнө албан тушаалын гэрэл дандаа ногоон өнгөөрч асч угтсан гэлтэй. Дээд сургуулиа төгссөн түүнийг ХААЯ алга тосон угтан авсан төдийгүй газрын даргаар хоёронтоо томилсон байдаг. Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулгад тэнцсэн эхний таван төрийн нарийн бичгийн дарга нарын нэг нь Л.Баяртуулга. Тэрбээр ажил авсан даруйдаа малчдад тулах аяныг санаачилсан нь И.Сэргэлэн сайдад ихээхэн таалагдсан гэнэ билээ.

### Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам- Г.ӨНӨРБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаярын тухайд нийгмийн салбарын чиглэлээр олон арван нийтлэл бичиж байсныг нь манай уншигчид мартаагүй байх. Японд докторын зэрэг хамгаалсан түүний үндсэн мэргэжил багш. Улс төрд хөл тавих хүртлээ Боловсролын салбарт ажилласан нэгэн. Энэ эрхмийн улс төрд хөл тавьсан түүхийг тэр бүр хүмүүс мэддэггүй юм. Шулуухан хэлэхэд, гэнэтхэн л гарч ирсэн нөхөр. Гадна төрх нь ч шөвөлзөж, амбиц хөөгөөд гүйгээд байхааргүй дөлгөөхөн бор залуу. Гэвч тэрбээр улс төрд хөл тавьмацаа л МАН-ын XXVII Их хурлын төлөөлөгч, Бага хурлын гишүүнээр сонгогдож амжсан төдийгүй, 2013 онд "Залуучууд дарга нарынхаа цүнхийг барьж гүйх хэрэггүй" хэмээж, МАН шинэчлэгдэх цаг болсон гэж намынхаа Бага хурлын индэр дээрээс зорилго нэгт нөхдийнхөө хамт мэдэгдэж байсан юм. Үүнийхээ шанд ч мань эр Монгол Улсын Ерөнхий сайдад шадарлаж, зөвлөхөөр ажилласан удаатай.

### Зам, тээврийн хөгжлийн яам- Ж.БАТ-ЭРДЭНЭ

Энэ эрхмийг УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн ах гэдгээр нь түмэн мэддэг. Тэрбээр дүү шигээ ардчилал, Ардчилсан нам гэж давхидаггүй. Улс төрийн хүрээнийхэн ах дүү хоёрыг улс төрийн ашиг хонжоо хайж хоёр өөр намыг сонгосон хэмээн голлох нь бий. Үнэнийг хэлэхэд, хоёр том улс төрийн хүчин ээлжилж

төрийн эрх барих бүрт мань хүн албан тушаалд томилогдсон л байдаг. Тухайлбал, хамтарсан Засгийн газрын үед 2011-2012 онд Мэдээллийн шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргаар ажиллаж байгаад засаг солигдоход дүүгийнхээ "Монголын цахилгаан холбоо"-ны гүйцэтгэх захирлын суудалд заларсан байдаг. Хэвлэл мэдээллийнхний архивт түүний тухай "Мэдээллийн шуудан, харилцаа холбоо, технологийн газар"-ын даргаар түүнийг ажиллаж байхдаа чагнах тоног төхөөрөмж суурилуулдагаараа зартай нь "ZTE" компанийг Монголд үйл ажиллагаа явуулахад хувь нэмрээ оруулсан гэж тэмдэглэгдэн үлджээ. Энэ талаараа тэрбээр "Намайг тус газрын даргаар очиход "ZTE" компани гэрээгээ хийгээд үйл ажиллагаа нь жигдэрсэн байсан. Тус компани Сангийн яамтай хамтарч ажиллах гэрээгээ байгуулсан байсан тул надад хамаагүй" хэмээн тайбарласан нь бий. Ж.Бат-Эрдэнийн улс төрд хөл тавьсан түүх бөгөөд 2004 онд МАН-д элссэн бөгөөд тэр ондоо тухайн үеийн Дэд бүтцийн яамны газрын даргаар томилогдсон байдаг. Түүнийг улс төрд өдий дайны нэр нүүртэй явахад нь төрсөн дүүгээс нь гадна Ерөнхий сайд асан Н.Энхбаяр намдаа элсэхийг санал болгож байсан юм билээ.

### Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам- Г.НАНДИНХИШИГ

Төрийн албаны зөвлөлийн шалгалтад тэнцсэн даруйдаа ажлаа хүлээж авсан хүн бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал билээ. Г.Нандинжаргал өмнө нь 2003-2010 онд Монгол банкны Мөнгөний бодлого судалгааны газарт эдийн засагч, 2010-2013 онд Нийслэлийн ЗДТГ-ын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, 2013 онд Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газрын орлогч дарга, 2013-2014 онд УХААЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, 2014-2015 онд УХААЯ-ны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, 2015-2016 онд "Эрдэнэс Монгол" компанийн дэд захирлын багт Төслийн захирлаар ажиллаж байжээ.

### Боловсрол, соёл, спортын яам- Б.БАЯРСАЙХАН

Б.Баярсайхан нь Монголын үндэсний пресс клубийн тэргүүн бөгөөд "Амин Медиа" группийн Ерөнхий захирлаар ажиллаж байсан нэгэн. Тэрбээр МҮОНТ-ийн "Өглөө" хөтөлбөрийн хөтөлгөч, редактор, Монгол Улсын Дээд шүүхэд хэвлэлийн төлөөлөгч, MCS группийн PR менежер, "Ийгл" телевизийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, удирдлагын чиглэлээр 15 жил ажилласан, туршлагатай нэгэн. МАН дахь шинэчлэлийн салхийг хагалж яваа цөөн бүсгүйчүүдийн нэг хэмээн улстөрч эмэгтэйчүүд үнэлэх нь бий.

### Сангийн яам-Б.НЯМАА

Санхүүгийн хүрээнийхэн түүнийг Төрийн нарийн бичгийн даргаар томилогдоход ажлаа мэддэг,

салбараа мэддэг хүн хэмээн алга ташин хүлээж авсан гэж хэлж болно. Үнэндээ ч тэрбээр санхүү, маркетингийн өлгий нутаг Японд санхүүгийн бодлого сэдвээр мастер хамгаалсан нэгэн. Б.Нямаа улсад алба хашсан тэр л өдрөөс өнөөдрийг хүртэл салбар дотроо эргэлдэж байгаа санхүүч. Үүнийг нь түүний намтар бэлхэнээ хэлээд өгөх буй за. Тодруулбал, 1999-2007 онд Төсвийн бодлого, зохицуулалтын газрын Зарлагын хэлтэс, Төсвийн нэгтгэлийн хэлтэст мэргэжилтэн, 2007-2013 онд Төсвийн бодлого, зохицуулалтын газрын Зарлагын хэлтсийн дарга, 2006-2007 онд Монгол дахь мянган сорилтын сангийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, 2013-2016 онд Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар, Санхүүгийн бодлогын газрын даргаар тус тус ажиллажээ. Б.Нямаагийн санхүүгийн салбарт зүтгэсэн ажлын туршлага нь Монгол Улс эдийн засгийн хямралыг хохирол багатайгаар туулж гарахад хэрэг болно хэмээн Монголын төр үзэж буй. Түүнд ганцхан гэм бий. Өөр шигээ хурдан сэтгэхийг хамт ажиллаж байгаа нөхдөөсөө шаарддаг явдал.

### Эрүүл мэндийн яам- Д.ОЧИРБАТ

Эрүүл мэндийн салбарт ч, улс төрд хэдийнэ танил болсон энэ эрхэм Төрийн нарийн бичгийн албан тушаалд томилогдсон цагаас толгой өндийх завгүй ажиллаж байгаа. Эрүүл мэндийн салбарыг шинэчлэхийг хүссэн салбарынхан нь түүнийг зүгээр суулгахгүй байгаагийн дээр томуу, томуу төст өвчний тархалт зовоож буй. Чингэлтэй дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа өрх толгойлсон эмэгтэйчүүд болон амьдрал авч явах гэж зүтгэх олон арван багачуудад хайр энэрийн гараа сунгаж, хашааны газар олгож, сургуульд сурах боломжийг олгож байсныг нь чингэлтэйчүүд мартаагүй. УИХ-ын чуулганы тахимд сууж байхдаа ч тэрбээр мөн л нийгмийн халамжийн чиглэлээр олон хуулийн төсөл санаачилж, нэлээд олон ажлын хэсгийг ахалж ажилласан байдаг. МАН-ыг унаж босоход нь хамтдаа унаж, босон ачааны хүндийг хүнд хэмээн зулралгүй урагшлахын төлөө зүтгэсэн цөөн улстөрчдийн нэг.

### Эрчим хүчний яам - З.МЭНДСАЙХАН

Санхүүч, эдийн засагч мэргэжилтэй түүнийг энэ салбарт томилогдоход эочим хүчнийхэн төдийлөн таатай хүлээж аваагүй. Төрд ажилласан туршлага, мэдлэг боловсролын тухайд З.Мэндсайхан хэнд ч гологдохооргүй. Тэрбээр намтартаа "1996 – 2001 онд СЭЗДС-ийг Эдийн засагч, бизнес судлаач мэргэжлээр төгсч 2006 – 2008 онд Удирдлагын академид Удирдахуйн ухааны магистр хамгаалсан тухайгаа өгүүлжээ. Сургууль төгссөн даруйдаа хувийн бизнесээ эрхлүүлсэн бөгөөд 2015 онд төрийн алба тодуулбал, Сангийн яаманд Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргаар томилогдон ажилласан байх юм. Улс төрд мөргүй, нэргүй явсан түүнийг албан тушаалын одтой залуу гэхээс өөр юу хэлэх билээ.

### Барилга, хот байгуулалтын яам- С.МАГНАЙСҮРЭН

Тэрбээр өмнө яамныхаа Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад эрүүл мэндийн шалтгааны улмаас өргөдлөө өгч төлөөлөгдсөн тухай мэдээлэл байдаг ч чухамдаа тэр нь улс төрийн шахалт байсан тухай улс төрийн хүрээнийхэн ярьцгаадаг. УИХ-ын Тамгын газрын даргын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан тэрбээр төрд ажилласан туршлагын хувьд эдүгээ ажиллаж байгаа ангийн анд нар дундаа толгой цохино. Түүнтэй олон жил шадарлаж, үерхэж явсан нөхөд нь жинхэнэ монгол эр гэж түүнийг хэлнэ хэмээн магтах юм билээ.

### Батлан хамгаалах яам- Х.БАТБИЛЭГ

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб гэх нэг салбарын хоёр байгууллага эв нэгдэлгүйгээсээ болоод сүүлийн 10 гаруй жил хоёр тийш хараад байсан билээ. Яг ийм эгзэгтэй цаг үед хурандаа Х.Батбилэгийг Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн даргаар томилсон нь энэ салбарт том олз гэлтэй. Олон жил хамтдаа зүтгэсэн Нийслэлийн Онцгой байдлын газрынхан нь даргаа "далайлт нь хатуу ч буулт нь зөөлөн хүн" хэмээн магтах. Ямартай ч тэрбээр ажил хүлээж авсан даруйд Батлан хамгаалах салбарыг жинхэнэ утгаар нь өөрчилж, номд нь оруулахын төлөө ажиллаж буй нэгэн гэдгийг хэлэх байна. Түүний санаачилсан, эхлүүлсэн ажлууд зэвсэгт хүчнийхэнд одоохондоо биелүүлэхэд бэрх мэт санагдаж болох ч цаг хугацааны дараа амжилтад хүрэх зам энэ байж гэх нь дамжиггүй.

### Байгаль орчин-аялал жуулчлалын яам-Ц.ЦЭНГЭЛ

Улс төрд, намдаа халзан болтлоо зүтгэсэн энэ эрхмийг түмэн мэднэ дээ. Ялангуяа, Булган нутгийнхан. Хурдан моринд л нугасгүй гэмтэйгээс улстөрчийн хувьд түүний өмнө гишгч Төрийн нарийн бичгийн дарга үгүй биз ээ. Тэрбээр Уралын Политехникийн дээд сургуулийг эрчим хүчний инженер мэргэжлээр дүүргэн ажил амьдралынхаа гарааг "ТЭЦ-3" аас эхэлсэн байдаг. УИХ-ын гишүүн асан Ц.Цэнгэл нь Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Зам тээвэр, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан бөгөөд эдүгээ Эрчим хүчний инженерүүдийн холбоог тэргүүддэг. Сонирхуулахад, МАН-ын Удирдах зөвлөлөөс Ц.Цэнгэлийг Эрчим хүчний сайдаар томилж шийдвэрт хүрсэн ч ерөнхий сайд УИХ-д өргөн барихдаа нэрийг нь эргүүлэн татсан билээ. Энэ тухайд ерөнхий сайд Ж.Эрдэнэбат "Нийгмийн хүлээлт, ёсгүй зарчим талаас нь мөн АТГ-ын холбогдох хуулийн лавлагаа зэргийг эргэж харах хэрэгтэй" гэсэн хувийн байр суурь илэрхийлсэн нь бий. Үүнийхээ дараа Ц.Цэнгэлийн сайд болох гэсэн гомдлыг тайлахын тулд үндсэн мэргэжлээс нь холдуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсон хэмээн намынх нь нөхөд ярьдаг.

## ЧУХАЛ СЭДЭВ



Гэрэл зургийг Г. АРТУУЖИН

## Д. Солонго:

## ҮНДСЭН ХУУЛЬ БОЛ МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ

Н. ПУНЦАГБОЛД

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, эрх зүйч, улс төр судлаач Д. Солонготой ярилцлаа.

**-Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой энэ онд тохиож байгаа. Зарим хүмүүс монголчууд 25 жилийн өмнө л анх удаагаа Үндсэн хууль баталсан гэж ойлгоод байдаг. Гэтэл бид түүнээс ч өмнө Үндсэн хуулиа батлаад, хэрэглээд явж байсан ард түмэн шүү дээ. Энэ талаар, үүх түүх талаас нь та яриач?**

-Монгол Улс түүхэндээ дөрвөн Үндсэн хууль баталсан. Анх 1924 онд анхны Үндсэн хуулиа баталсан байдаг. Ази тивдээ анх Үндсэн хуультай болсон орон гэж хэлж болно. Тэр хуулинд төрийн байгууллагуудын тогтолцоо, улсынхаа бүрэн эрхт байдлын үндсийг анхлан тунхагласан гээд ач холбогдолыг нь тоочиж болохоор. Харин ард түмнээ жинхэнэ, жинхэнэ бус хэмээн ялгаж тусгасан байдаг. Түүнээсээ болоод сонгох, сонгогдох эрхтэй холбоотой хязгаарлалтууд байсан нь мэдээж учир дутагдалтай. Түүний дараа 1940 онд Монгол Улс хоёр дахь Үндсэн хуулиа батлан гаргасан. Тэр

хуулинд нэлээд дэвшилттэй гэж хэлж болохоор нэмэлт, өөрчлөлтүүд 1949 онд орсон байдаг юм. Ингэснээр 1949 оноос иргэдээ жинхэнэ, жинхэнэ бус гэж ялгах аа больж, эрх тэгш байх үндсийг Үндсэн хуулиараа тогтоон хуульчилсан. Одоо хүмүүс нэг зүйлийг яриад байдаг. Тухайлбал, аймгуудын болоод яамдын нэр, тоог Үндсэн хуулиар хуульчлах нь зүйтэй гэж. Дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийг хараад байхад түүний хамрах хүрээ гэж тогтсон ойлголт байгаа юм. Тэр утгаар нь харвал, аймаг, яамдын нэр, тоог Үндсэн хуулиар хуульчлах нь нийтлэг жишиг биш. Би сая 1940 оны хуулийг ярьж байгаад гэнэт энэ талаар дурьдлаа. Яагаад гэвэл 1940 оны Үндсэн хуульд энэ асуудлыг хуульчилж өгсөн байдаг юм. БНМАУ-ын яамд гээд жагсаачихсан. Мөн аймгуудын нэрийг дугаарлаад жагсаачихсан байсан юм. Хэрвээ Үндсэн хуулиар аймаг, яамдын нэр, тоог хуульчлаад өгчигхвөл байсгээд л өөрчлөлт оруулах шаардлага тулгарна. Яамдыг татан буулгах, нийлүүлэх, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх болгонд л Үндсэн хуулиндаа “гар хүрэх” болно. Гэтэл Үндсэн хуулинд “гар хүрэх”, нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг бол тийм ч амархан,

1990-ээд онд дөрөв дэх Үндсэн хуулиа батлахаар ярилцаж байхдаа өмнөх гурван хуулиас наад зах нь нэр томьёо, цаад зах нь утга санаанаас авахуулаад уламжлагдаж ирсэн зүйлүүд багагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Атар газар эзэмшсэн хэрэг огт биш. Энэ далимд хэлэхэд, Монгол Улс хоёрхон Үндсэн хуультай. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийг дөрөв дэх гэж хэлдэг нь буруу хэмээн зарим нэг хүмүүс ярьж байхыг сонссон юм байна.

гарын үзүүрээр хийчих ажил биш шүү дээ. Дэлхий нийтэд ч тийм байдаг. Тийм учраас аймаг, яамдын асуудлыг цаг үетэйгээ нийцүүлээд, уян хатан байдлаар журамлаж өгсөн нь зөв гэж хувь хүний үүднээс үздэг. 1940 оны Үндсэн хуулинд байсан нэг том онцлог энэ учраас дурьдлаа. Тэгвэл 1960 онд манай улс гурав дахь Үндсэн хуулиа батлан гаргасан. Хоёр дахь Үндсэн хууль 20 жилийн хугацаатай хэрэгжжээ гэж ойлгож болох нь. Харин 1990 онд буюу 30 жилийн дараа 1960 оны Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Энэ

хуулиар төрийн тогтолцоо, нийгмийн улс төрийн тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд хийгдсэн, тухайлбал олон намтай байх Үндсэн хуулийн эрх зүйн үндэс бүрдсэн. Манайх улс төрийн нэг дэглэмээс нөгөө рүү шилжихдээ тайван замаар шилжсэн гэж ярьдаг биз дээ. Энэ шилжилтэд үнэтэй хувь нэмэр оруулсан үйл явдал бол 1960 оны Үндсэн хуулинд 1990 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан үйл явц гэж би хувь судлаачийн үүднээс үздэг. Тайван замаар шилжилт хөдөлгөөн хийх эрх зүйн үндсийг үүгээр бүрдүүлж өгч. Яах аргагүй Монголын түүхэнд сайнаар тэмдэглэгдэх

ёстой үйл явдал юм шүү дээ.

**-Хүмүүс 1992 онд цоо шинээр л Үндсэн хууль баталсан гэсэн ойлголттой байдаг. Гэтэл 1924, 1940, 1960 онд гурван ч удаа Үндсэн хууль баталж байж. Тэр хуулиудын үндэс суурь шинэ Үндсэн хуулинд байгаа биз дээ. Эсвэл өмнөх Үндсэн хуулиудыг огт хайхрахгүй орхиод, цоо шинээр баталчихсан юм уу?**

-Энэ бол хамгийн сонирхол татсан асуудал. Бид 1924 онд Азид анх удаагаа Үндсэн хууль баталсан ард түмэн гэдгийг дахиад хэлье. Тэгэхээр, 1990-ээд онд дөрөв дэх Үндсэн хуулиа батлахаар ярилцаж байхдаа өмнөх гурван хуулиас наад зах нь нэр томьёо, цаад зах нь утга санаанаас авахуулаад уламжлагдаж ирсэн зүйлүүд багагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Атар газар эзэмшсэн хэрэг огт биш. Энэ далимд хэлэхэд, Монгол Улс хоёрхон Үндсэн хуультай. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийг дөрөв дэх гэж хэлдэг нь буруу хэмээн зарим нэг хүмүүс ярьж байхыг сонссон юм байна. Тэр бол учир дутагдалтай. Мөн чанарын хувьд ангилал юм бол 1924, 1940, 1960 онд батлагдсан Үндсэн хуулиуд социалист чиг баримжаатай, тэр үзэл баримтлалын дагуу

боловсруулагдаж, батлагдаж, мөрдөгдөж байсан. Харин 1992 оны Үндсэн хууль бол Ардчилсан шинэ хууль шүү дээ. Үүгээрээ эхний гурван Үндсэн хууль нэг ангилалд багтаж байгаа юм. Энэ талаас нь харж, ярьж болох юм. Түүнээс биш бид яахын аргагүй дөрөв дэх Үндсэн хуулиа батлаад, мөрдөөд явж байна. Энэ хууль маань ч өмнөх гурваасаа залгамжлагдаж ирсэн. Би энд Б.Чимид багшийгаа дурьдмаар байна. Тэр хүний төр, нийгмийн төлөө оруулсан хувь нэмэр маш их. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн хүн байсан шүү дээ. Тийм болохоор би багшийнхаа тухай яримаар байна. Б.Чимид багш өөрөө “Би тийм юм хийсэн шүү” гэж ярьдаг хүн байгаагүй юм. Өөрийнх нь хажууд жаахан магтаад ярихаар таатай хүлээж авдаггүй байсан. Тийм болохоор би энд дурсахыг хүсч байна.

**-Тэгэлгүй яахав, та Үндсэн хууль батлахын өмнө ямар судалгаа хийсэн, юу болж байсан талаар сайхан түүх огуулэх байх?**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 19  
Тендер шалгаруулалтын нэр: ҮБХИС, ЦТЭ-ийн хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: БХЯ/201700001

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтэй гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 5.5867.620 төгрөг, 2-р багцад 887.400 төгрөг, 3-р багцад 1.873.600 төгрөг, 4-р багцад 1.023.740 төгрөг, 5-р багцад 636.450 төгрөг, 6-р багцад 309.480 төгрөг, 7-р багцад 235.480 төгрөг, 8-р багцад 509.170 төгрөг, 9-р багцад 1.660.540 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10.30 цагт дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.

Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд  
Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө.  
Утас: 95584084, Г.Хандмаа

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 01 дүгээр сарын 19  
Тендер шалгаруулалтын нэр: ҮБХИС, ЦТЭ-ийн хэрэгцээт хувцас хэрэглэл нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: БХЯ/201700002

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос хувцас хэрэглэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтэй гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 1.587.084 төгрөг, 2-р багцад 187.434 төгрөг, 3-р багцад 316.800 төгрөг, 4-р багцад 408.850 төгрөг, 5-р багцад 221.065 төгрөг, 6-р багцад 706.266 төгрөг, 7-р багцад 94.380 төгрөг, 8-р багцад 731.352 төгрөг, 9-р багцад 506.379, 10-р багцад 290.700 төгрөг, 11-р багцад 786.100 төгрөг, 12-р багцад 116.360 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 12.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 12.30 цагт дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.

Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г.Хандмаа

# ЧУХАЛ СЭДЭВ

үедээ олж харж, мэдэрсэн. Тийм болохоор 1960 оны Үндсэн хуульд өөрчлөлт хийх, дараачийн Үндсэн хуулиа бодох цаг болсныг мэдэрч, судалгаануудыг залуу багш нараар хийлгэж байжээ гэж би боддог. Бид бүх судалгаагаа улс улсаар нь хүснэгтлээд, нарийвчилсан маягаар гаргаж байсан. Өдөр болгон автобус зогсох дөхөх хүртэл судалгаагаа хийнэ. Орой болсон хойно хоёулаа гараад, Хүнсний 20 дугаар дэлгүүрийн буудал хүртэл алхана. Би тэндээсээ хороолол явах автобусанд сууна. Ц.Сарантуяа багшийнх Циркийн хажууд байсан болохоор урагшаа ганцаараа гүйдэг байлаа. Олон орой бид хоёр хамтдаа явж, судалгаа хийж байсан юм. Одоо бодоход, Б.Чимид багш маань Үндсэн хуулийг өөрчлөх хэрэгтэй юм байна. Дэлхий нийтийн Үндсэн хуульд нийтлэг ямар зүйл байдаг юм бэ гэдгийг судлах шаардлагатай гэдгийг олж харж, биднээр хийлгэж байж дээ гэж бодогдож юм. Энэ бол тэр хүний Монгол Улсад оруулсан маш том хувь нэмэр, гавьяа.

**-Шинэ Үндсэн хууль батлагдаад 25 жил болжээ. Энэ хугацаанд Үндсэн хуулийн талаар янз бүрээр л ярьдаг. Гадны хуулийг тэр**

Тийм учраас Үндсэн хуулийг Монголын ард түмний оюуны хамтын бүтээл гэж хэлэхээс өөр арга байхгүй.Тэгээд бүр 200 мянга гаруй санал гарсан. Үндсэн саналуудыг утсаар, бичгээр хүлээж авч байлаа. Санал авах ажлыг маш сайн зохион байгуулсан. Анхны Ерөнхийлөгч П.Очирбат гуай Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч нь байлаа шүү дээ. Үндсэн хуулийн төслийг байгууллага, хамт олон болгоноор хэлэлцүүлж байсан. Хэлэлцүүлсэн хуралдааны тэмдэглэлийг хөтөлж байлаа. Гарсан саналуудыг зүйл бүрээр нь тэмдэглэнэ. Тэгээд санал бүрийг багцлаад, сэдэв сэдвээр ангилж байсан юм. Түүний дараа төв комисстоо бүх санал, хүсэлт, тэмдэглэлээ хүргүүлж байсан. Ирүүлсэн бүх саналын 44.3 хувийг төсөлд тусгасан. Энэ бол нотолгоо баталгаатай юм шүү дээ. Хүмүүс утсаар саналаа өгсөн бол иргэн тэрнээс тэдэн сарын тэдний өдөр тийм саналыг өгөв гэж тэмдэглэж байсан юм шүү дээ. Ингэж л Үндсэн хуулийг баталсан. Түүнээс биш хэн нэгэн бидэнд бэлэглэхчлэн, эсвэл шууд хуулаар орчуулсан юм шиг ярьдаг, боддог бол буруу шүү. Ард түмэн даяараа хөдөлж, хөлхөж байж шинэ Үндсэн

...Ирүүлсэн бүх саналын 44.3 хувийг төсөлд тусгасан. Энэ бол нотолгоо баталгаатай юм шүү дээ. Хүмүүс утсаар саналаа өгсөн бол иргэн тэрнээс тэдэн сарын тэдний өдөр тийм саналыг өгөв гэж тэмдэглэж байсан юм шүү дээ. Ингэж л Үндсэн хуулийг баталсан. Түүнээс биш хэн нэгэн бидэнд бэлэглэхчлэн, эсвэл шууд хуулаар орчуулсан юм шиг ярьдаг, боддог бол буруу шүү. Ард түмэн даяараа хөдөлж, хөлхөж байж шинэ Үндсэн хуулийг бүтээсэн юм...

байгаа. Гэтэл сурах эсэх нь хүний эрх. Өөрөө хүсвэл сурна биз, үгүй бол болино биз дээ, хуулиас хасна гэвэл Үндсэн хууль хэрэгжиж байгаа цагт хэзээ ч үл хэрэгжих асуудал. Харин нэмье гэвэл болно. Өөрчлөх асуудал байж болно. Эрх мэдлийн хуваарилалт дээр гажуудал байна, өөрчилж гэхэд болно. Үүнийг үгүйсгэхгүй байна. Харин заавал тав дахь Үндсэн хууль батлах энэ тэр гэж яриад хэрэггүй. Манай улс 1924-1992 оны хүртэл дөрвөн Үндсэн хууль баталчихсан. Үндсэндээ 70 жилийн хугацаанд шүү дээ. Гэтэл 70 жил гэдэг нэг улсын хувьд тийм ч урт хугацаа биш. Улс битгий хэл хувь хүний амьдралд ч 70 жил гэдэг урт биш гэж хэлж болно. 70 гарчихсан хүмүүс он жилүүд ямар хурдан өнгөрчихдөг юм бэ дээ гэдэг биз дээ. Гэтэл энэ хугацаанд манай улс дөрвөн Үндсэн хууль баталчихсан байна. Ялангуяа эхний гурван хуулийг 20 гаруй жилийн зайтай баталж байж. Гэхдээ нийгмийн хөгжилтэйгээ холбоотой л доо. 1924 оны Үндсэн хуулийг шилжилтийн үеийнх гэж тодорхойлчихсон. Харин 1940 оныхыг болохоор Социализмын үндсийг тавих үеийнх. 1960 оны Үндсэн хуулийг социализмын материал техникийн баазыг

тэгвэл чи тэгнэ, төр биднийг хамгаална, бид ч эргээд эх орноо хамгаална, татвар төлнө гэх мэтээр байгуулсан гэрээ гэж хэлж болно. Харин өнөө үед нийгэм ямар болсон билээ. Цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдүүд багшийн харцаар нэг зүг харахаа больсон цаг. Өөр өөрийнхөө олж авсан, харсан, үзсэнийхээ хэрээр санаагаа хэлээд, ярьдаг болчихсон. Ийм үед нэгдсэн нэг зорилгод хүрээд, шинэ Үндсэн хуулийг баталчихна гэдэг тийм ч амархан ажил биш. Хэлэхэд бол амархан байх л даа. Хийхэд хэцүү л гэж би боддог. Харин

**гишүүдээс ийм хандлага гарах гээд байдаг юм шиг ажиглагддаг?**

-Би судлаач хүний хувьд нэг зүйлийг хэлж. Парламентын олон жилийн түүхтэй улс орнуудыг хараад байхад парламентат ёсны нэг том соёл байдаг. Парламент гэдэг хамтын удирдлагын байгууллага. Нэг гишүүн ганцаараа хэзээ ч хууль баталдаггүй. Бүр нэгжгээд гишүүн байлаа ч батлахгүй. Олонхиор баталдаг. Тэгээд хуулийн төслийг боловсруулах, өргөн барих, ажлын хэсэг, байнгын



# ОЮУНЫ ХАМТЫН БҮТЭЭЛ

**чигт нь орчуулаад гаргасан, манайд тохирохгүй гэх мэтээр. Энэ тал дээр та юу хэлэх вэ?**

-1980-аад оны дунд үеэр гадаад орнуудын Үндсэн хуулийг судлуулж байхад Ц.Сарантуяа багш бид хоёроос гадна С.Төмөр багш энэ ажилд оролцож, санаа оноогоо хэлж, зөвлөгөө өгдөг байсан. Б.Чимид багшид судалгаагаа танилцуулахын өмнө редакцийн ажил хийж, нэгтгэж оролцож байсан. Энэ жил Үндсэн хууль баталсны 25 жилийн ой болж байгаа хэдий ч 30 гаруй жилийн өмнөөс судалгаа хийх ажлыг нь эхлүүлж байсан юм шүү дээ. Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдахад нарийвчилсан, дэлгэрэнгүй судалгаанууд хангалттай хийгдэж байсан. Энэ ажилд салбар салбарын эрдэмтэн судлаачид, төлөөлөл оролцсон, өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан. Зөвхөн төсөл боловсруулагдахаас гадна боловсруулагдсан төсөл дээр хэлэлцүүлэг явагдсаны дараа эцсийн хэлэлцүүлэгт орохын өмнө 10-аад дэд хэсгийг байгуулсан. Би лав “Шүүх эрх мэдэл, хүний эрх” гэдэг Л.Цог даргаар ахлуулсан дэд хэсэгт орж ажилласан. Манай ажлын хэсэгт нэлээд олон эрдэмтэн, судлаач багтсан. Бид байгууллага, хамт олон, иргэдээс ирсэн санал, мөн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг нэг бүрчлэн уншиж, судалж, Үндсэн хуулинд оруулах боломжтой эсэхээр нь ялгагдаж байлаа. Л.Цог даргын өрөөнд бүгдээрээ цуглаад, ширээ тойрч сууж байгаад л уншина. Тэр үед “Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цаазлах хэрэгтэй. Тийм учраас үүнийг Үндсэн хуулинд тусга” гэсэн санал ч зөндөө гарч байсан. Гэтэл Үндсэн хууль бол ялын бодлогын үндсийг тогтооно. Ямар ял оногдуулах нь Эрүүгийн хуулийн асуудал юм гэж үзээд л харуу өгнө. Гэх мэтчилэн санал болгонд харуу өгч байсан. Таны саналыг Үндсэн хуулинд тусгалаа гэдгээ ч эргэж мэдэгдэнэ. Тэр болгоныг нэг нь бичиж авна. Ийм техник ажлыг үнэхээр хийсэн юм шүү. Тухайн үед манай улс 1.2 сая сонгогчтой байсан. Тэр хүмүүсийн 75 орчим хувь нь буюу давхардсан тоогоор 900-гаад мянган хүн Үндсэн хуулийн төслийг хэлэлцэх үед шууд оролцсон.

хуулийг бүтээсэн юм.

**-Сүүлийн үед бас дахиад өөр шинэ Үндсэн хууль батлах ёстой ч гэсэн явган яриа байдаг. Тав дахь Үндсэн хуулиа батлах цаг болсон гэх мэтээр ярьдаг шүү дээ. Энэ тал дээр та судлаач хүний хувьд ямар бодолтой явдаг вэ?**

-1992 онд баталсан Үндсэн хууль 25 жил үйлчилсэн, одоо хангалттай. Тийм болохоор дараагийн Үндсэн хуулиа баталж гэж ярих хүн бий. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль гэж батлагдсан. Өмнө нь тийм хуульгүй явж ирсэн. 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой сайн, муу янз бүрийн хэл ам гардаг. Энэ тал дээр хэн нэг хувь хүн үнэлэлт дүгнэлт өгдөг ч асуудал биш байх. Би ч гэсэн энд тийм дүгнэлт хийх гэсэнгүй. Ер нь бол тэр үед нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль гэж байгаагүй. Үндсэн хуулийн зургадугаар бүлгийн 68, 69, 70 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай заалт байдаг юм. Тэр гуравхан зүйлийг бариад бүхэл бүтэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэхээр бас учир дутагдалтай шүү дээ. Тиймээс Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг батлан гаргах шаардлагатай байна гэж үзээд баталсан гэж ойлгодог. Энэ хуулийг гаргахын тулд 200-гаад улсын Үндсэн хуулийг судалсан. Би ажлын хэсэгт нь багтаж, судалгааны багт нь ажилласан. Биднээс өмнө Үндсэн хуультай болсон маш олон орон байгаа шүү дээ. Ер нь 1787 оны АНУ-ын Үндсэн хуулийг хүн гартаа бариад уншиж болох хамгийн анхны хууль гэж дэлхий нийт хүлээн зөвшөөрдөг. Тэр хуулиас авахуулаад үе үеийн хүчин төгөлдөр бүхий 200-гаад орны Үндсэн хуулийг судалсан. Тэр дундаа 120 орчим улсын Үндсэн хуулийг нарийвчлал, нягталсан. Ажлын хэсгийн гишүүд улсуудын Үндсэн хуулиудыг хувааж аваад л судалсан. Үндсэн хуулийг хэн, ямар саналын хувиар баталдаг юм. Хэдэн үе шаттай баталдаг юм гэдгээс авахуулаад 10 орчим асуулгаар шалгуур тавьж байгаад түүнийг дагуу судалгаа хийсэн. Би гэхэд Тусгаар нөхөрлөлийн хамтын нийгэмлэгт багтдаг 12 орны Үндсэн хуулийг судалж,

хүснэгтлээд тушааж байсан. Ер нь улс орнууд Үндсэн хуулиндаа нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд ямар журам баримталдаг вэ гэдгийг судалж үзсэн хэрэг. Тэр бүхнийг харж, судалж байж бие даасан хууль гаргаж, баталсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Хэрвээ Үндсэн хуулиндаа гар хүрнэ гэвэл энэ хуулийг дагаж, мөрдөж ажиллана. Ер нь би Үндсэн хуулинд тэр бүр гар хүрээд байх хэрэггүй л гэж үздэг.

**-Сүүлийн үед Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах цаг болсон гэж улстөрч болон ярих боллоо. Төрийн байгуулалтын талаасаа өөрчлөлтүүд хэрэгтэй байна гэх юм. Үнэхээр тэгэх хэрэгтэй болчихсон юм уу?**

-Үндсэн хууль батлагдсан л бол хэзээ ч, хэн ч өөрчилж болохгүй, энэ чигээрээ байх ёстой гэсэн юм байхгүй шүү дээ. Үндсэн хуулинд ерөнхий зарчмуудыг суулгаад, төрийн байгууллагуудын эрх мэдлийг оноочтой хуваарилаад, суурь зарчмуудаа хуульчилчихсан. Харин УИХ-ын, Засгийн газрын, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудаараа тогтсон суурь зарчим, зохицуулалтаа дэмжээд, дэлгэрүүлээд зохицуулаад явдаг жишиг дэлхий нийтээр байна. Тэгсэн ч гэсэн тодорхой цаг хугацааны эрхээр нэмэлт, өөрчлөлт хийх шаардлага гарч таарна шүү дээ. Тухайлбал, хоёрдугаар бүлэг буюу хүний эрхийн жагсаалт дээр нэмээд шинэ эрх оруулж болно. Өмнө нь тусгаагүй эрх байна. Тухайлбал, хүн бүр орон сууцтай байх эрх гэж тусгаагүй. Гэтэл зарим улсын Үндсэн хуулинд тусгаж өгсөн байдаг. Хүний амьдрах орон байр гэдэг эрүүл байх, сурч боловсрох, ажиглаж хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэхийн үндэс болж өгдөг. Орох оронгүй, оочих аягагүй хүн сурч боловсрох эрхээ хэрэгжүүлнэ гээд яваад байвал учир дутагдалтай биз дээ. Тийм болохоор хүн бүр орон сууцтай байх суурь эрхийг хэрэв манай улсын эдийн засаг дааж чадвал тусгаж өгөх хэрэгтэй. Энэ бол өөрчлөлт биш нэмэлт. Нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулинд тодорхой заагаад өгчихсөн байгаа. Одоо байгаа эрхүүдээс хасч болохгүй, харин нэмж болно. Жишээлбэл, сурч боловсрох эрхтэй гэсэн заалт

барьж байгуулах үеийнх гэж ангилдаг. Хөгжлийн нэг шатнаас нөгөө рүү шилжихэд Үндсэн хуулиараа бэхжүүлдэг гэж үздэг. Гэтэл манайхны зарим нь 1992 оны шинэ Үндсэн хуулийг шилжилтийн үеийн хууль гээд байдаг. Бид марксист-ленинист онолоос татгалзсан гэж ярьдаг байж буцаад түүнийгээ сэргээгээд, тухайн үеийн формацийн онолоороо Үндсэн хуулийнхаа үечлэлийг авч үзвэл дэвшээд байна уу, ухраад байна уу гэдэг асуудал яригдана биз дээ. Иймээс тав дахь Үндсэн хууль батлан гаргана гэвэл нийгмийн их л том өөрчлөлтийн үр дүнд яригдах асуудал байхаа. Харин одоогийн Үндсэн хуульд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт оруулахыг үгүйсгэдэггүй. Жишээ нь, гишүүдийн тоо 76 байгааг нэмнэ гэж ярьдаг. Зөв ч байж болно, буруу ч байж бас болох. Би түүнийг дүгнэхгүй. Үнэхээр шаардлага байвал ард нийтээрээ хэлэлцээд, өөрчилж болно шүү дээ.

**-Одоо Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд ард түмнээр хэлэлцвэл иргэд тийм ч идэвхтэй оролцохгүй болов уу гэж бодогдох юм?**

-Шинэ Үндсэн хуулийг батлах гэж байх үед бол хуулийн төслийг сонинуудад хэвлэж, телевизээр маш их хэлэлцүүлэг өрнүүлсэн. Тэр үед ямар олон телевиз ч байсан биш. Орой ажлаасаа ирээд, зурагтаа асаахаар Үндсний телевизээр ажлын хэсгийн гишүүд, судлаачид, сонирхсон иргэд оролцсон дутуй ширээний ярилцлага, хэлэлцүүлэг гээд олон нэвтрүүлэг гарна. Радиооор мөн олон нэвтрүүлэг цацаж, асуудлыг ярьдаг байлаа. Тэр үед нэг сайхан зүйл нь иргэдийн дунд ялгарал гэхээр юм байгаагүй. Тэр дундаа хөрөнгө чинээгээрээ ялгардаг зүйл бараг алга байсан. Бид чинь 45-ын гутал өмсөөд, 7.20-ын хиама идэж, 11.20-ын чихэр хүлхэж явсан. Гэтэл өнөөдөр өнөөх есийн тосыг чинь транс тос л гэнэ. Таалагдах юм олдохоо больсон. Зөвхөн хоолоо шарах тос хүртэл үнээрээ өөр өөр болчихсон. Ганц ургамлын тос л ямар их ялгарал үүссэнийг харуулж байгаа биз дээ. Ийм байхад хүмүүс санаа нэгтгэж, шинэ Үндсэн хуульд санаа оноогоо өгөөд, оролцдог явах уу. Үндсэн хуулийг чинь нийгмийн гэрээ ч гэж үздэг. Төр иргэний хооронд байгуулсан гэрээ. Би

30-аад жилийн өмнө хамтраад зүтгээд, энэ сайхан оюуны бүтээлийг би болгочихоод, өнөөдөр муучлаад байх шаардлагагүй. Нэг л жаахан юм болохгүй болохоор Үндсэн хуулиас л болсон гээд байдаг. Ийм яриаг олон сонсч байна. Үндсэн хууль гэдэг хоёр талын хоорондын харилцааг ч ия тэг, ингэ гэж нарийвчлан зохицуулдаг хууль огт биш. Нийгмийн суурь харилцааг зохицуулдаг. Монгол Улсын 1.5 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр дээр төрийн байгуулал гэсэн малгайн дор ямар ямар байгууллагууд байх юм, хэн нь юу хийх гэдэг хуваарийг нь тогтоож өгнө. Харин яаж хийх вэ, ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байх вэ гэдгийг ердийн хуулиар зохицуулна шүү дээ. Гэтэл асуудлаа ердийн хуулиараа олжитойхон зохицуулчихаж чадахгүй, эсвэл тэр хуулиа олжитойхон хэрэгжүүлэхгүй байж юм болохоор л Үндсэн хуулийн буруу гээд байдаг. Дээрээс нь нийгмийн харилцааны үндсийг тогтоон зохицуулсан хуультай байна гэдэг нэг асуудал, харин түүнийгээ нэг мөр хэрэгжүүлэх гэж бас нэг асуудал байна. Манайх хэрэгжүүлэх дээрээ хуулийг санаатай, санамсаргүйгээр буруугаар тайлбарладаг, эсвэл хуулийн утгыг мушгин гуйвуулдаг, үгүй бол өөрөө агуулгыг нь буруу ойлгоод тэрийгээ бусдад тулгах, гэх мэт хандлагууд түгээмэл байна.

**-Тэр дундаа УИХ-ын**

хороод, нэгдсэн чуулганд хэлэлцүүлэх явцад өөрөө эсрэг байр суурьтай байвал тэр санаа, онолоо батлаад, яаж эсэргүүцэж, улайрч, тэмцэлдэх нь парламентын гишүүний бүрэн эрхийн асуудал. Харин хууль олонхийн саналаар батлагдсаны дараа сөрөг талын хоорондын харилцааг ч ия тэг, ингэ гэж нарийвчлан зохицуулдаг хууль огт биш. Нийгмийн суурь харилцааг зохицуулдаг. Монгол Улсын 1.5 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр дээр төрийн байгуулал гэсэн малгайн дор ямар ямар байгууллагууд байх юм, хэн нь юу хийх гэдэг хуваарийг нь тогтоож өгнө. Харин яаж хийх вэ, ямар бүтэц бүрэлдэхүүнтэй байх вэ гэдгийг ердийн хуулиар зохицуулна шүү дээ. Гэтэл асуудлаа ердийн хуулиараа олжитойхон зохицуулчихаж чадахгүй, эсвэл тэр хуулиа олжитойхон хэрэгжүүлэхгүй байж юм болохоор л Үндсэн хуулийн буруу гээд байдаг. Дээрээс нь хууль парламентаас гардаг болохоос гишүүний баталсан хууль гэж байхгүй. Эээн, зохиогчгүй байдаг шүү дээ, хууль чинь. Харин сүүлийн үед би санаачилсан хууль гээд зохиогчтой болгох гээд байдаг хандлага гарах болсон. Энэ бол парламентад ёсонд хүлээн зөвшөөрч болохоогүй зүйл байдаг юм билээ. Харин хуулийг батлагдаад гарсны дараа эрдэмтэд судлаачид хэрэгжилтийн байдлыг нарийвчлан судлаад шүүмжилж болно. Хэрэгжилтийнх нь явцад бас иргэд ийм байна, тийм асуудал байна гээд санал бодлоо илэрхийлж болох юм.

**Хүчингүйд тооцов**

БЗД-ийн II хороон дахь Д.Цэцэгэгийн өмчлөл бүхий 29.18м² газар өмчлөлийн шийдвэрийг гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Сүхбаатар Дүүргийн 71-р сургуулийн 2007013 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тул хүчингүйд тооцов

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Y-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул хүчингүйд тооцов.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

## “Бүргэдтэй АЖУУ”



Б.СУМЬЯА

Дэлхийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “Sony world photography awards-2016” наадмын мэргэжлийн гэрэл зурагчдын төрөлд тэргүүн байр эзэлсэн нэгэн бүтээлийг уншигчиддаа сонирхуулж байна. Тус наадмын мэргэжлийн

төрөлд дэлхийн 10 гаруй орны чадвар, чансаатай мэргэжлийн гэрэл зурагчид 14 номинациар бүтээлүүдээ өрсөлдүүлжээ. Улмаар Канадын уран бүтээлч Кэвин Фраэр хоёр ч номинацид шилдгээр шалгарсан байна. Түүний нэг нь дээрх “Бүргэдтэй анчид” цуврал зураг юм. Энэ зураг “Байгальорчин” номинацид шилдгээр

шалгарчээ. Гэрэл зурагчин Монгол, ОХУ, Казахстантай хиллэх БНХАУ-ын баруун этгээдийн уулархаг нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан уламжлалт “Бүргэдийн баяр”-т оролцох үедээ дээрх зургийг дурандаа буулгажээ. “Бүргэдийн баяр”-ыг орон нутгийн Ан, агнуурын нийгэмлэгээс уламжлалт бүргэдтэй

анг олон нийтэд сурталчлан таниулах, залуу үеэ бэлтгэх, туршлагажуулах зорилгоор зохион байгуулдаг байна. Казах бүргэдтэй анчид махчин том шувуутай хэрхэн харьцах, сургах зэрэг эргэний дүрэм журмыг баримтлах бөгөөд түүнийгээ залуу үеийнхэндээ ч мөн уламжлуулдаг ажээ.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -19  
Шөнө -28

Нөгөөдөр  
Өдөр -19  
Шөнө -29

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН МОРЬ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.34-17.32  
Үс засуулбал: Идээ ундаа элбэг олддоно



Тухайн өдөр баяр, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ал даргах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнээвэл жуулчин ирэх, хэрэг дуугарвал зочин ирэх, тагнай загатанал алгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэлцэл болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

Бидэнд тохиолдсон

Ням Каа  
Хүндхэн хөгтэй явдлууд

Ням Каа

Би хоёр дүүтэй юм л даа. Том нь 12-той, бага нь дөрвөн настай. Нэг удаа том ах нь дүүгээ унтуулахаар болж, тэврэлдээд л хэвтсэн юм. Хэсэг хугацааны дараа би зөөлнөөр “Яасан унтуулсан уу” гээд асуусан чинь өмнөөс бага дүү “Дөнгөж сая унтлаа. Битгий сэрээчих” гэх юм. Хэн нь хэнийгээ унтуулаад ч байгаа юм. Кккккк

ДУУЛГАХ СОНИН

### “Сайн аав” тун удахгүй...

“Про стар” филмсийн бүтээл Good Dad “Сайн Аав” Монголын уран сайхны кино энэ сарын 20-нд нээлтээ хийхээр товлосон байна. Үзэгчдийн дунд маш их хүлээлт үүсгэж буй уг киног таксини жолооч, мундаг аав хэмээн ард түмэнд танигдсан Т.Даваасүрэн агсны гэгээн дурсгалд зориулан гэргий Д.Амаржаргалынх нь хүсэлтээр бүтээжээ. Тус киноны продюссерээр “Про стар” филмсийн захирал С.Чулуунтогтох ажилласан юм. Харин найруулагч С.Бүжин Good DAD “Сайн аав” уран сайхны киноны зохиолыг бичиж, өөрөө ерөнхий найруулагчаар нь ажиллажээ. Тэгвэл Монголын кино урлагт эмэгтэй найруулагч хуруу дарам цөөн гэдгийг үзэгч олон мэдэх билээ. Эмэгтэй хүний торгон мэдрэмж, нямбай ажиллагаа харагдсан уг кино группт олон чадварлаг уран бүтээлч хамтран ажилласан байна. Киноны голд дүрд жүжигчин, найруулагч, МУСТА С.Баттулга, Ш.Жавхлан, таван хүүхдийн дүрд Т.Даваасүрэн агсны том охин Д.Энхжин болон И.Мөрөн, Б.Хачиун, Э.Индра, Б.Ариун-Итгэл нар тогложээ. Мөн туслах дүрүүдэд жүжигчин, МУСТА Н.Ялалт, С.Батзориг буюу Ишчү, Т.Энэрэл зэрэг олон чадварлаг жүжигчид оролцон тогложээ. Дашрамд дурьдахад, “Про стар” филмсийн ээлжит уран бүтээл болох 2D “Шидэт хуудас” бүрэн хэмжээний хүүхэдтэй кино ч ирэх хавраас олны хүртээл болох гэнэ.



### “Болор цом”-г 80 гаруй найрагч бүтээлээ ирүүлжээ

МЗЭ-ээс жил бүр уламжлал болгон зохиож, оны шилдэг яруу найраг, шилдэг шүлэгч тодруулдаг утга уянгын “Болор цом” наадам энэ жил эх орны зүүн хязгаар Дорнод аймагт болох билээ. 2005 оноос Эрдэнэт, Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Төв аймагт болж байсан бол энэ удаагийн наадмын бэлтгэл ажил хэдийнэ хангагджээ. Өнөөдрийн байдлаар “Болор цом”

наадамд 80 гаруй найрагч бүтээлээ ирүүлээд байгаа аж. Урд жилүүдээс олон найрагч шүлгээ илгээсэн ч дүрэм ёсоор шилдэг 30 бүтээлийг шалгаруулж, тайзнаа өрсөлдүүлэх юм байна. Яруу найрагчдын бүтээл хүлээж авах хугацаа ирэх баасан гаригт дуусахыг эх сурвалж мэдээлэв. Тэртээ 1983 онд анх зохиогдсон цагаас хойш өдгөө 44 дэх жилийнхээ босгыг алхаж буй юм.

### “ХУВЬСАЛ”-ЫН Урнаа бүтэн нүцгэлэв

Дэлгэцийн уран бүтээлд аль хэдийн өөрсдийн гэсэн байр суурийг эзэлж чадсан “Хувьсал” продакшны шинэхэн уран бүтээл “Миний нууц” кино тун удахгүй үзэгчдэд хүрэхэд бэлэн болжээ. Киноны постер эдүгээ цацагдаж эхэлсэн бөгөөд гол дүрд тоглож буй МУГЖ У.Уранчимэг чармай нүцгэн зургаараа постероо чимсэн нь үзэгчдийн анхаарлыг ихээхэн татаж байна. Жүжигчин бүсгүй эдүгээ 43 настай. Хэдий тийм ч, биеийн галбираа төгс хадгалж, сайхан хэвээрээ л байгаа нь үеийн бүсгүйчүүдийн атаархлыг төрүүлдэг нь дамжиггүй. Харин энэ удаа киноны шинэ постерыг МУГЖ У.Уранчимэг хоёр гараараа цээж хэсгээ далдалж, чармай нүцгэн байдалтайгаар хэвтэж буй зургаараа чимсэн нь сошиал сүлжээнд ёстой л гал авалцуулж байна. Кино ирэх гуравдугаар сарын 2-нд нээлтээ хийх бөгөөд найруулагчаар нь Д.Галбаяр ажиллажээ.

### “Япон киноны өдрүүд”-г ХҮРЭЛЦЭН ИРЖ, АЗТАН БОЛОВРОЙ



Монгол Японы найрамдалт харилцаа тогтоосны 45 жилийн ойд зориулан “Япон киноны өдрүүд” энэ сарын 18-20-ны өдрүүдэд Тэнгис кино театрт зохион байгуулагдах гэж байна.

10 дахь удаагийн “Япон киноны өдрүүд” арга хэмжээг Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Япон сан хамтран зохион байгуулж байгаа аж. Түүнчлэн энэ өдрүүдийн ихэвчлэн хөдөө аж ахуйтай холбоотой, хэрхэн хөдөлмөрлөж байгаа талаар ихээхэн сургамжтай кинонуудыг дэлгэцнээ гаргаж, олны хүртээл болгохоор зорьжээ.

Тодруулбал, “FOOD CINEMA” буюу Японы хүнс үйлдвэрлэлийн ажлын талбарыг сэдвээ болгосон доорх 5 бүтээлийг үзүүлэхийн зэрэгцээ дэлхийд алдартай Макото Шинкай найруулагчийн анимэ бүтээл “Үгсийн Цэцэрлэг”-ийг толилуулах гэнэ.

Кино өдрүүдийн эхний үзвэрийн өмнө нээлтийн ёслол болох бөгөөд (1 сарын 18 өдрийн 15:00 цаг) Монгол Улсад суугаа Япон улсын Элчин сайд М.Такаока үг хэлж мэндчилгээ дэвшүүлэх аж. Мөн “Food Cinema” сэдэвтэй таван бүтээлийг үзүүлсний дараа Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй япон хоолны ресторана болох “Totoya Dining”, “Sushi HERO” нарын зүгээс уг арга хэмжээг дэмжин ажиллаж, кино үзэхээр хүрэлцэн ирсэн үзэгчид дундаас сугалаагаар дээрх ресторануудаар үйлчлүүлэх эрхийн бичгийг бэлэглэх гэнэ.

Киноны хөтөлбөр:

Тусгай үзвэр - Макото Шинкай найруулагчийн бүтээл

1 сарын 19 (Пүрэв):  
15:00~ КАРА АГЭ USA (2014 он, 95 мин)  
18:00~ Яндашгүй Далай (2014 он, 84 мин)

1 сарын 20 (Баасан):  
15:00~ Мөнгөн Халбага (2014 он, 111 мин)  
18:00~ Усан Үзмийн Нууц (2014 он, 117 мин)